



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ДАРГА САНДАГИЙН БЯМБАЦОГТ  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Энхбатын БОЛОРМАА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-31-46, Факс: 32-70-16  
E-mail: bolormaa.e@parliament.mn  
http://www.parliament.mn

2026. 05.21 № УИХ-03/5748  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд “Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хуулийн төсөл, холбогдох тайланг хавсаргав.

Хавсралт *1db* хуудастай

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

Э.БОЛОРМАА

Д.АМАРБАЯСГАЛАН

А.АРИУНЗАЯА

Х.БААСАНЖАРГАЛ

О.БАТНАЙРАМДАЛ

Х.БУЛГАНТУЯА

М.ГАНХҮЛЭГ

Б.ЖАРГАЛАН

Л.ГАНТӨМӨР

000086

*[Handwritten signature]*  
М.НАРАНТУВА-НАРА  
Ч.НОМИН  
О.НОМИНЧИМЭГ  
Г.ОЧИРБАТ ✓ *[Handwritten signature]*  
Д.ПҮРЭВДАВАА *[Handwritten signature]*  
П.САЙНЗОРИГ  
О.САРАНЧУЛУУН  
Л.СОРОНЗОНБОЛД  
Л.ЭНХНАСАН  
С.ЭРДЭНЭБАТ



УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Энхбатын БОЛОРМАА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-31-46, Факс: 32-70-16  
E-mail: bolormaa.e@parliament.mn  
http://www.parliament.mn

2026. 05.19 № УИХ-03/5644  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
тов тогтоолгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд “Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулийн төслийг боловсрууллаа.


Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү

Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, холбогдох судалгааг хавсаргав .

Хавсралт *1/23* хуудастай

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Э.БОЛОРМАА

000084



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Э.БОЛОРМАА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.04.07 № 1037/106

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуралдааны тэмдэглэл  
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлсэн Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг үүгээр хүргүүлж байна.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Б.ЭНХБАЯР

000265005002

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

“11.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаагийн санаачлан боловсруулсан Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлт

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаагийн санаачлан боловсруулсан Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1.Хуулийн төслийн зорилтыг санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санхүүгийн хэрэглэгчид хүргэхэд тавигдах нийтлэг шаардлагыг тогтоох, санхүүгийн хэрэглэгчийн хууль ёсны эрхийг хамгаалах замаар санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэхээр тодорхойлж, үйлчлэх хүрээг санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ авахаар сонирхож байгаа, эсхүл үйлчилгээ авсан санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахаар тусгажээ.

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт банк болон банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний чиглэлийн тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааны төрлүүдийг тодорхойлж, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт санхүүгийн үйл ажиллагаа, үйлчилгээний төрлийг тус тус нарийвчлан зохицуулсан.

Гэтэл хуулийн төсөлд “санхүүгийн үйлчилгээ” гэдгийг “санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс санхүүгийн хэрэглэгчид санал болгож, нийлүүлж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээ” гэж тодорхойлсон нь давхардсан, ойлгомжгүй найруулгатай байх бөгөөд хуулиар тодорхойлсон нэр томъёоны хувьд зөрүүтэй ойлголт үүсэж болзошгүй байх тул санхүүгийн бүтээгдэхүүн, санхүүгийн үйлчилгээ, үйл ажиллагааны ялгааг оновчтой байдлаар ялган тодорхойлох нь зүйтэй.

Мөн Зөвшөөрлийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд тус тус заасан санхүүгийн үйлчилгээнээс санхүүгийн хэрэглэгчийн авах бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл, хэлбэрээс хамааран түүний хамгаалуулах, зөрчигдөж болзошгүй эрх ашиг нь ялгаатай тул хуулийн төсөлд ерөнхий, нийтлэг зохицуулалт тусгахаас илүүтэйгээр санхүүгийн хэрэглэгчийн хуулиар хамгаалах эрх ашгийн төрөл, тухайн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд тохирсон мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг хангах чиглэлээр нарийвчилсан зохицуулалтыг тусгах замаар хуулийн төслийн хамрах хүрээ болон бусад зохицуулалтыг тодорхойлох;

2.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 11 дүгээр зүйлд хийгдэхээр хүлээгдэж байгаа гүйлгээ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилготой гэж үзэх үндэслэлтэй тохиолдолд Санхүүгийн мэдээллийн алба тухайн гүйлгээг ажлын гурав хүртэл өдрийн хугацаагаар түдгэлзүүлэх, мөн

хуулийн 13 дугаар зүйлд санхүүгийн байгууллага нь Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлсэн гүйлгээтэй холбоотой аливаа мэдээллийг бусад этгээдэд дамжуулах, задруулахыг хориглох зохицуулалттай тул харилцагч тус хуульд заасны дагуу шаардсан мэдээллийг өгөхөөс татгалзвал санхүүгийн байгууллага нь түүнд үйлчилгээ үзүүлэхээс татгалзах үүрэгтэй.

Иймд хуулийн төслийн 3 дугаар зүйл буюу хуулийн үйлчлэх хүрээнд “Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд энэ хууль хамаарахгүй” гэж нэмэх нь зүйтэй байна.

Дээрх зохицуулалттай уялдуулан хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд тусгасан “1.3.санхүүгийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзсан тохиолдолд үндэслэл бүхий тайлбарыг санхүүгийн хэрэглэгчид мэдэгдэх үүргээ биелүүлээгүй” гэснийг “1.3.санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхээс бусад тохиолдолд үндэслэл бүхий тайлбарыг санхүүгийн хэрэглэгчид мэдэгдэх үүргээ биелүүлээгүй” гэж өөрчлөн найруулах;

3.Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.9, 4.1.10 дахь заалтад “санхүүгийн үйлчилгээний бодит өртөг”, “зээлийн бодит өртөг”-ийг тодорхойлохдоо “санхүүгийн үйлчилгээний нийт зардлыг багтаасан”, “бусад нэмэлт зардлыг багтаасан” гэж ерөнхий байдлаар тодорхойлсон нь зардлын бүрэлдэхүүн тодорхой бус, нуугдмал зардлыг санхүүгийн хэрэглэгчээс шаардах, зардлыг өргөн хүрээтэй тайлбарлах боломж олгох, улмаар талуудын хооронд маргаан үүсгэх тодорхойгүй нөхцөлийг бүрдүүлэх тул зардлын төрөл, бүрэлдэхүүн, хамрах хүрээг тодорхой болгож, хуулийн төслийн зорилго болох санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлд нийцүүлэх;

4.Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1.7 дахь заалтад тусгасан олон нийтийн санхүүгийн боловсролыг дэмжих зарчмыг төслийн Гуравдугаар бүлгийн 8 дугаар зүйл буюу санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэгт тусгаж, олон нийтийн санхүүгийн боловсролыг дэмжих үүргийг санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдэд хүлээлгэх;

5.Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтад санхүүгийн хэрэглэгчид санхүүгийн үйлчилгээ авснаас хойш ажлын 3 хоногийн дотор торгууль, хураамж, шимтгэл, төлбөргүйгээр гэрээг цуцлах, буцаах эрх олгосон нь санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах ач холбогдолтой хэдий ч уг зохицуулалтын бодит хэрэгжилт, тухайлбал зээлийн бүтээгдэхүүн болон төлбөр тооцооны үйлчилгээтэй холбоотойгоор санхүүгийн байгууллагад үүсэх эрсдэлийг харгалзан үзэж, шаардлагатай бол санхүүгийн үйлчилгээний төрөл тус бүрээр хэрэгжүүлэх нөхцөлийг тодорхойлох;

6.Хуулийн төслийн 7 дугаар зүйл буюу санхүүгийн хэрэглэгчийн үүрэгт “Харилцагч нь энэхүү үүргийг биелүүлээгүй, эсхүл санаатайгаар худал, төөрөгдүүлсэн мэдээлэл өгсөн тохиолдолд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь хуульд заасан журмын дагуу үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, үйлчилгээний хүрээг хязгаарлах, харилцааг зогсоох арга хэмжээ авах үндэслэл болно.” гэсэн агуулгатай 7.2 дахь хэсгийг нэмэх;

7.Хуулийн төслийн 8 дугаар зүйл буюу санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг тодруулж, мөн зүйлийн 8.1.12 дахь заалтад санхүүгийн хэрэглэгчид гэрээний гол нөхцөлийг танилцуулах, тайлбарлах, санхүүгийн хэрэглэгчийн асуултад ойлгомжтой, энгийн хэллэгээр хариулах үүргийг нэмж тусгах, уг зохицуулалтыг хэрэгжүүлэх хүрээнд мэдээлэл өгөх стандарт, агуулгыг илүү тодорхой болгох шаардлагатай.

Хуулийн төслийн 8 дугаар зүйлд дараах агуулгатай 8.2 дахь хэсгийг нэмж тусгах нь зүйтэй. Үүнд:

“8.2.1.Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомжийн дагуу харилцагчаас мэдээлэл, баримт бичиг шаардах, харилцагчийг таньж мэдэх, эрсдэлийн түвшинг тодорхойлох арга хэмжээ авах болсон үндэслэлийг харилцагчид ойлгомжтой, энгийн хэллэгээр тайлбарлах үүрэгтэй.

8.2.2.Энэ зүйлийн 8.2.1-д заасан тайлбар өгөхдөө тухайн харилцагчийг сэжигтэйд тооцсон эсэх, сэжигтэй гүйлгээний тайлан илгээсэн эсэх талаар болон дотоод эрсдэлийн үнэлгээ, шалгалтын нарийвчилсан мэдээллийг ил болгохыг хориглоно.

8.2.3.Харилцагчид тайлбар өгөхдөө “мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу” гэдэг ерөнхий үндэслэлийг дурдсан байхыг хангалттайд тооцно.”

Мөн төслийн 8 дугаар зүйлд энэ хуулийн 10.4-т заасан хяналтын хуудас, түүний ач холбогдлыг санхүүгийн хэрэглэгчид танилцуулж, тайлбарлах үүргийг нэмж, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, хориглох зохицуулалтаас гадна санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн эрхийн зохицуулалтыг тус тус нэмж тусгах;

8.Хуулийн төслийн 9 дүгээр зүйл буюу санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид хориглох зүйлд санхүүгийн хэрэглэгчид сэтгэл санааны болон бусад хэлбэрийн дарамт үзүүлэх, хэрэглэгчийн хувийн болон санхүүгийн мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд дамжуулахыг хориглох зохицуулалт нэмж тусгах;

9.Хуулийн төслийн 10 дугаар зүйлд санхүүгийн үйлчилгээнд тавигдах шаардлага, мэдээллийн ил тод байдлыг зөвхөн санхүүгийн үйлчилгээний танилцуулга буюу мэдээллийн чанартай баримт бичигтэй холбоотой зохицуулалтаар хязгаарласан нь хангалтгүй байна. Энэхүү баримт бичиг нь санхүүгийн үйлчилгээ, бүтээгдэхүүнд тавигдах шаардлагыг дангаараа илэрхийлэх хэмжигдэхүүн болох боломжгүй.

Санхүүгийн үйлчилгээ, бүтээгдэхүүний чиглэл, үйл ажиллагааны төрлөөс хамааран санхүүгийн үйлчилгээ, мөн санхүүгийн бүтээгдэхүүнд тавигдах шаардлага харилцан адилгүй бөгөөд нийтлэг, ерөнхий байдлаар тавигдах шаардлагыг тусгах нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч болон санхүүгийн хэрэглэгчийн эрх ашигт нийцэхгүй байх тул тавигдах шаардлагыг санхүүгийн үйлчилгээ, санхүүгийн бүтээгдэхүүний чиглэл, үйл ажиллагааны онцлог тус бүрд нийцүүлэн нарийвчлан тусгах.

Түүнчлэн уг зүйлд санхүүгийн хэрэглэгчийн санхүүгийн үйлчилгээ авах болсон шалтгаан, нөхцөл, хувь хүний болон санхүүгийн мэдээллийг нийтийн дунд (үйлчилгээний заал танхимд, бусад үйлчлүүлэгчийн дэргэд, нийтэд сонсогдох нөхцөлд) авахгүй байх, мөн санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчтэй гэрээ байгуулахдаа гэрээний агуулга, зүйл, заалтыг холбогдох хуульд нийцүүлэн товч, тодорхой боловсруулах, үсгийн фонт, хэмжээг стандартын дагуу тогтоож, хэрэглэгч уншиж танилцахад ойлгомжтой, гаргацтай байхад анхаарах зэрэг зохицуулалтыг тусгах;

10.Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсэгт гомдлын шаардлага гаргах хугацааг 6 сар байхаар тусгасныг Иргэний хуульд заасан гомдлын шаардлага гаргах болон хөөн хэлэлцэх хугацаатай нийцүүлэх;

11.Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт “Санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллага албан татвар, хураамж шимтгэлээс чөлөөлөгдөнө” гэж

тусгасан нь татварын хууль тогтоомжид нийцэхгүй байна. Тухайлбал, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.10 дахь заалтад ашгийн төлөө бус хуулийн этгээдийн дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэхтэй холбоотой олсон аж ахуйн үйл ажиллагааны орлогыг албан татвараас чөлөөлөх зохицуулалттай бөгөөд Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт татварыг зөвхөн Улсын Их Хурал татварын хуулиар хөнгөлөх, чөлөөлөх эрхтэй гэж заасан тул төслийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийг хасах;

12.Хуулийн төсөлд санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллагыг “төрөөс үүсгэн байгуулсан, ашгийн төлөө бус хуулийн этгээд” гэж тодорхойлсон нь Төрийн бус байгууллагын тухай хуульд заасан “ашгийн төлөө бус байгууллага”-тай андуурагдах, улмаар ашгийн төлөө бус төрийн бус байгууллагыг төрөөс үүсгэн байгуулах, тус байгууллагын дарга, гишүүдийг төрөөс томилох зохицуулалт нь Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “төрийн бус байгууллага нь төрөөс хараат бус байна” гэж заасан зарчимд нийцэхгүй, эрх зүйн хувьд зөрчилтэй байх нөхцөл бүрдүүлж байна.

Түүнчлэн, санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллага нь Удирдах зөвлөл, маргааныг хянан шийдвэрлэх омбудсман болон ажлын албанаас бүрдэх бөгөөд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч болон санхүүгийн хэрэглэгчийн хооронд гарсан санхүүгийн үйлчилгээтэй холбогдох маргааныг шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгажээ.

Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт зааснаар санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч болон санхүүгийн хэрэглэгчийн хооронд үүсэх гомдол, маргааны төрөл нь хууль болон гэрээгээр тодорхойлсон эрх зөрчигдсөнтэй холбоотой гэрээний харилцаанаас үүдэлтэй иргэний эрх зүйн шинжтэй байх тул энэ төрлийн маргааныг урьдчилан шийдвэрлэх төрийн байгууллага байх, түүний Удирдах зөвлөлийн гишүүнийг Улсын Их Хурлаас томилж, чөлөөлөх зэрэг нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан төрийн эрх мэдэл хуваарилах зарчим, харилцан хамаарал, хяналт, тэнцвэр бүхий төрийн байгууллагын зохицуулалтад нийцэхгүй байх тул хуулийн төслийн Зургадугаар бүлгийг бүхэлд нь хасах;

13.Санхүүгийн хэрэглэгчийн гомдол, маргааныг шийдвэрлэхтэй холбоотой буюу омбудсманы үйл ажиллагаанд анхаарах хэд хэдэн зохицуулалтыг хуулийн төсөлд тусгажээ. Тухайлбал:

-Хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт “омбудсманы шийдвэрийг зөвхөн санхүүгийн хэрэглэгч хүлээн зөвшөөрөөгүй бол... шүүхэд гомдол гаргаж болно” гэж тусгасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж заасан зарчимд нийцээгүй байна;

-Хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.6 дахь хэсэгт “...омбудсманы шийдвэрт холбогдох маргааныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар, Улсын дээд шүүх давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэнэ” гэж тусгажээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Захиргааны хэргийн шүүх Үндсэн хуулийн цэц болон өөр шүүхэд харьяалуулснаас бусад нийтийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэж, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт “Захиргааны хэргийн анхан шатны шүүх энэ хуульд заасны дагуу захиргааны хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.” гэж Захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлэх маргааны харьяаллыг заасан.

Иймд хуулийн төсөлд тусгасан омбудсманы гаргасан шийдвэрийг захиргааны байгууллагын шийдвэртэй адилтгах боломжгүй бөгөөд захиргааны байгууллагын эрхгүй этгээд тул Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нийцэхгүй байна.

Мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 156 дугаар зүйлийн 156.1.1 дэх заалтад “шүүх, прокурор, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага болон Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд зааснаас бусад байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаанд хуульд заасны дагуу гаргасан гомдол”-ыг шүүх авч хэлэлцэх хуулийн зохицуулалттай болохыг анхаарах.

-Хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.7 дахь хэсэгт “санхүүгийн хэрэглэгч омбудсманы гаргасан шийдвэрт энэ хуульд заасан хугацаанд шүүхэд гомдол гаргаагүй бол эцсийн шийдвэр болно” гэж, төслийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэгт “талууд тогтоосон хугацаанд баримт, мэдээлэл гаргах үүргээ биелүүлээгүй бол омбудсман гомдлыг буцаах, эсхүл маргааныг аль нэг талд ашигтайгаар шийдвэрлэх” зохицуулалтыг тус тус тусгасан байна.

Омбудсманы гаргасан шийдвэр нь хууль зүйн хүчин чадлын хувьд маргаантай, хэрэгжилт хангалтгүй байх, маргааныг аль нэг талд ашигтайгаар шийдвэрлэх зохицуулалт нь шийдвэр алдаатай, нэг талыг барьсан, эцсийн шийдвэр болох тохиолдолд засагдах боломжгүй, шүүхэд хандах хүний суурь эрхийг хязгаарласан, шүүхийн хяналтгүй болох зэрэг зөрчил үүсэх, талуудын эрхийн хамгаалалт сулрах эрсдэл, сөрөг үр дагаврыг үүсгэж болзошгүй байна.

Хууль, эрх зүйн орчны хувьд санхүүгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Хүний эрхийн Үндэсний Комисс зэрэг байгууллагууд Төв банк /Монголбанк/-ны тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай зэрэг холбогдох бусад хуулиар олгогдсон тус тусын чиг үүргийн хүрээнд санхүүгийн үйлчилгээг зохицуулсан салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих үүргийг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Монгол Улсад хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, шүүх, прокурор, Үндсэн хуулийн цэц, төрийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, Хүний эрхийн Үндэсний Комиссоос бүрдэнэ.” гэж, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын иргэн дангаар, эсхүл хамтарч Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө зөрчсөн талаар гомдол, мэдээллээ гаргах эрхтэй бөгөөд Комисс Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой аливаа асуудлаар санал, зөвлөмж гаргаж, эрх бүхий байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд хүргүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж байгаа бөгөөд Комиссын гишүүн нь тодорхой хэмжээнд омбудсманы чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Иймд омбудсманы эрх зүйн байдлыг тодорхойлсон олон улсын туршлага, тогтолцооны хувьд тохиромжтой хувилбар эсэхийг нарийвчлан судалж, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч, санхүүгийн хэрэглэгч буюу иргэн, хуулийн этгээд хооронд үүссэн хүний эрхийн зөрчилтэй холбоотой гомдол маргааныг шийдвэрлэхийн хувьд омбудсман төрийн харьяалалд хараат бус этгээд байх шаардлагатай тул дахин нягтлан судлах нь зүйтэй байна;

14.Санхүүгийн маргаан хянан шийдвэрлэх байгууллагын санхүүжилттэй холбоотойгоор хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллагын эхлэлийн санхүүжилтийг Монголбанкнаас бүрдүүлнэ.” гэж,

мөн зүйлийн 14.5-д “Шаардлагатай тохиолдолд Санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор Монголбанк болон улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.” гэж тус тусгажээ.

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасны дагуу Монголбанк иргэн, хуулийн этгээдэд санхүүгийн буцалтгүй тусламж үзүүлэхийг хориглосон тул хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.5 дахь хэсгийг хасах;

15.Хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллага хүлээн авсан гомдлоор маргаан үүсгэхээс татгалзах нөхцөлүүдийг тусгасан нь гомдол, маргааныг хянан шийдвэрлэх замаар санхүүгийн хэрэглэгчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хуулийн төслийн зорилго болон төслийн үзэл баримтлалд нийцэхгүй байгааг анхаарах;

16.Хуулийн төслийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийг “Иргэдийн санхүү, эдийн засгийн боловсролыг дээшлүүлэх стратегийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.” гэж өөрчлөн найруулах;

Мөн зүйлийн 23.3 дахь хэсэгт тусгасан санхүүгийн боловсрол дээшлүүлэх үйл ажиллагаанд баримтлах зарчимд “23.3.6.банк, санхүүгийн байгууллагууд хамтран нөлөөллийн арга хэмжээг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах.” гэж нэмэх;

17.Хуулийн төслийн Дөрөвдүгээр бүлэгт санхүүгийн үйлчилгээнд тавигдах шаардлагыг зохицуулсан атлаа төслийн 24 дүгээр зүйлийн 24.3.1 дэх заалтад зохицуулагч байгууллагаас санхүүгийн үйлчилгээнд тавигдах нөхцөл, шаардлага, хязгаарлалтыг зохицуулахаар дүрэм, журам, заавар, аргачлал батлах эрх олгосон нь давхардал үүсгэхээр байна. Иймд уг эрх олгосон заалтыг хасаж, төслийн Дөрөвдүгээр бүлэгт санхүүгийн үйлчилгээнд тавигдах үндсэн шаардлагыг хуулийн түвшинд илүү нарийвчлан тусгах нь зүйтэй.

Түүнчлэн, санхүүгийн үйлчилгээнд тавигдах шаардлагын дээд хязгаарыг тогтоохоор зорьж байгаа тохиолдолд түүнийг тодорхой, нэг мөр ойлгогдохуйц байдлаар тусгах, зөвхөн тодорхой байгууллагын бүтээгдэхүүнд бус, зээлийн харилцаанд нийтлэг үйлчлэх байдлаар, мөнгө хүүлэлтээс сэргийлэх зорилгод нийцүүлэн тусгах;

18.Хуулийн төслийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт “Зохицуулагч байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 24.2.3 дахь заалтад “санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтыг хэрэгжүүлэх” гэж зохицуулахаар тусгасан нь одоо хүчин төгөлдөр хэрэгжиж буй бусад хууль тогтоомжтой зөрчилтэй, давхардсан шинжтэй байна. Тухайлбал, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.9 дэх хэсэгт “...хэрэглэгчийн эрхийг хохироосон гэрээ байгуулахыг хориглоно.” гэж, Өрсөлдөөний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.10 дахь заалтад аливаа аж ахуй эрхлэгч нь “хууль ёсны ашиг сонирхолд харшлах болон хэрэглэгчийг хууль бусаар хохироох худалдааны арга хэрэглэх”-ийг хориглохоор заасан. Хуулийн эдгээр зохицуулалтын хэрэгжилтэд өрсөлдөөн, хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн захиргааны байгууллага хяналт тавих зохицуулалттай тул хуулийн төсөлд тусгагдсан дээрх зохицуулалт зөрчилдөж болзошгүй, тус агентлагийн үйл ажиллагааг хууль хоорондын уялдаагүй байдлаар хязгаарлах нөхцөл бүрдэхээр байна. Мөн зохицуулагч байгууллага хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нь сонирхлын зөрчил үүсэх, хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг бууруулах шалтгаан болж болзошгүй байх тул хэрэглэгчийн нийтлэг эрх, ашиг сонирхол зөрчигдсэн эсэхэд хяналт шалгалт хийх чиг үүргийг өрсөлдөөн, хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн захиргааны байгууллага хариуцахаар өөрчлөн тусгах;

19.Хуулийн төслийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт “Зохицуулагч байгууллагууд зээлийн бодит өртөг тооцох аргачлалыг хамтран батална.” гэж зөвхөн зээлтэй холбогдуулан тусгасан байна. Гэвч хуулийн төсөлд “санхүүгийн үйлчилгээ” гэж санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс санхүүгийн хэрэглэгчид санал болгож, нийлүүлж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээг гэж тодорхойлсноор санхүүгийн үйлчилгээний хүрээнд зөвхөн зээлээс гадна Үнэт цаасны зах зээлийн тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай, Даатгалын тухай хууль зэрэг салбарын хууль тогтоомжид тусгагдсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ бүхэлдээ хамаарахаар байх тул зөвхөн зээлийг онцлох нь хуулийн төслийн хамрах хүрээ болон санхүүгийн үйлчилгээ гэсэн нэр томъёоны тодорхойлолттой нийцэхгүй байгааг анхаарах;

20.Хуулийн төслийн 24 дүгээр зүйлийн 24.6.5 дахь заалтад “зохицуулагч байгууллага санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны зөвшөөрлийг хуульд заасны дагуу түдгэлзүүлэх, хүчингүй болгох, хасах” арга хэмжээ авах эрхтэй гэж тусгажээ.

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1-д эрх бүхий этгээд тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэр гаргах эрхийг хэрэгжүүлэх бөгөөд энэхүү харилцааг уг хуулиар зохицуулахаар заасан. Харин санхүүгийн салбарын хувьд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо нь харьяалах салбарын хууль тогтоомжийн хүрээнд дээрх бүрэн эрхийг хэрэгжүүлж байх тул хуулийн төслийн дээрх зохицуулалтыг дахин нягтлах;

21.Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалтад “зохицуулагч байгууллага” гэж Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороог” гэж тодорхойлж, мөн төслийн 24 дүгээр зүйлд Зохицуулагч байгууллагын бүрэн эрхийн талаар зохицуулалтыг тусгажээ.

Ингэхдээ тухайн бүрэн эрхийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо аль аль нь хэрэгжүүлэхээр тусгасан нь ойлгомжгүй бөгөөд эрх, үүргийн давхардлыг бий болгох үр дагавартай байгааг анхаарч, Төв банк /Монголбанк/-ны тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд заасан бүрэн эрх, чиг үүрэгт нийцүүлэн тус байгууллагуудын бүрэн эрхийг тус бүрд нь ялгамжтайгаар тусгах;

22.Хуулийн төсөлд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, санхүүгийн боловсрол багатай эмзэг бүлгийн хэрэглэгчдэд зориулсан санхүүгийн эрсдэлээс хамгаалах зохицуулалтыг нэмж тусгах;

23.Зээлдүүлэгчээс зээл олгох үйлчилгээний хүрээнд зээлийн хүү, шимтгэл, алданги, бусад төлбөрийн хэмжээ хэт өндөр, харилцан адилгүй тогтоогдож байгааг харгалзан зээлийн нийт өртөг буюу зээлийн хүү, шимтгэлийн дээд хязгаарыг эрх бүхий байгууллага тогтоохтой холбоотой зохицуулалтыг нэмж тусгах;


24.Төсөлд зээлдэгч “Банк, эрх бүхий хуулийн этгээд болон бусад зээлдүүлэгч этгээдээс зээл олгохдоо зээлдэгчийн нийт сарын төлбөрийг суутгасны дараа үлдэх орлого нь амьжиргааны баталгаажих доод түвшнээс багагүй байх” гэсэн иргэний амьжиргааны баталгаажих доод түвшинг хангахтай холбоотой зохицуулалт нэмэх. Мөн энэхүү заалтыг шууд хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэх зээлдэгчид буюу нэгэнт өрийн дарамтад орсон зээлдэгчдийн хувьд хуулийн зохицуулалтыг үе шаттай хэрэгжүүлэх боломжоор хангах;

25.Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийн шударга, өрсөлдөөнт зах зээлийг дэмжих нь санхүүгийн хэрэглэгчдэд бүтээгдэхүүн, үйлчилгээний өргөн сонголт бий болгох, үйлчилгээ үзүүлэгчдийг чанартай, өрсөлдөхүйц бүтээгдэхүүн санал болгоход чиглүүлэх, улмаар санхүүгийн хүртээмжийг тэлэх, үйлчилгээний чанарыг хадгалах

чухал ач холбогдолтой тул санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийн шударга өрсөлдөөнийг хамгаалахтай холбоотой зохицуулалтыг тус хуулийн төсөлд нэмж тусгах;

26. Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах, санхүүгийн үйлчилгээ үзүүлэх харилцаанд хяналт шалгалт хийхтэй холбоотойгоор Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг дагалдуулан боловсруулах.

Хуулийн төслийг санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах олон улсын зарчимд нийцүүлэн санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс санхүүгийн хэрэглэгчид хүргэх бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, хүртээмж, оролцоо, эмзэг бүлгийн хэрэглэгчийн эрхийн хамгаалалтыг сайжруулах, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэж, харин санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч болон санхүүгийн хэрэглэгчийн хоорондын гэрээнээс үүссэн гомдол, маргааныг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан харьяаллын дагуу шийдвэрлүүлэх нь зүйтэй байх тул дээрх санал, үндэслэлийг судалж, хуулийн төсөл болон дагалдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг нягтлан, дахин боловсруулах шаардлагатай.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**БАТЛАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**

**Э.БОЛОРМАА**

(2026 оны 2 дугаар сарын 25-ны өдөр)



## **САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

### **Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Их Хурлаас 2018 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр баталсан Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Монголбанкинд “банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах” мандат шинээр нэмэгдсэн.

Түүнчлэн УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоолоор баталсан Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэлийн 2-т “санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулж, санхүүгийн маргааныг олон улсын шилдэг туршлагад үндэслэн шийдвэрлэх оновчтой тогтолцоог бүрдүүлэх”-ээр, 2021 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэлийн хавсралтын 3.3-т “санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд иргэд, бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн суурь мэдлэгийг дэмжих”-ээр тус тус тусгагдсан.

1991 онд Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжиж банкны 2 шатлалт тогтолцоо бий болж Монгол Улсын Төв банк болох Монголбанк банкны салбарын үндсэн зохицуулагчаар ажиллаж эхэлсэн бөгөөд бодлогын бүх шатанд банкны салбарыг хөгжүүлэх, бэхжүүлэхэд ихээхэн анхаарч ирсэн байдаг. Банк, санхүүгийн салбар нь Монгол Улсын эдийн засгийн төдийгүй нийтлэг хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулж ирсэн бөгөөд хөгжлийнхөө явцад дутагдалтай байсан зүйлүүдээ засварлаж боловсронгуй болгосоор байгаа билээ.

Өнөөгийн банк, санхүүгийн салбарт тулгамдаж байгаа харилцагч, хадгаламж эзэмшигчийн хууль ёсны эрхийг хамгаалах хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага нь Дэлхийн банкны “Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах сайн туршлага” судалгаа<sup>1</sup>, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Ассамблей санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах шинэчилсэн удирдамж болон Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг

<sup>1</sup> <https://openknowledge.worldbank.org/bitstream/handle/10986/28996/122011-PUBLIC-GoodPractices-WebFinal.pdf?sequence=5&isAllowed=y>

урьдчилан тандан судлах судалгааны тайлангаас харагдаж байгаа ба Нэгдсэн Үндэсний байгууллагаас дэлхийн санхүүгийн зах зээл дээр үүссэн 2008 оны хямрал нь "санхүүгийн хэрэглэгч"-ийн эрх ашгийг хамгаалах үр дүнтэй арга хэмжээ дутмаг байгааг харуулсан сургамж болсныг дүгнэсэн байдаг. Энэ нь улс орнууд санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль тогтоомж, бодлого хэрэгжүүлэгч агентлагуудыг бий болгоход түлхэц болсон. Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалахад хууль, эрх зүйн акт боловсруулах, зохицуулагч байгууллага болон хяналт шалгалтын тогтолцоо байх ёстой гэж үзсэн байдаг<sup>2</sup>.

Монгол улсад санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой зохицуулалтыг "Иргэний хууль", "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль", "Өрсөлдөөний тухай хууль" зэрэг хуулиудад ерөнхий байдлаар тусгасан боловч тус харилцааг нарийвчлан зохицуулсан тусгайлсан хууль байхгүй байна. Түүнчлэн Банкны тухай хууль, Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Банк бус санхүүгийн байгууллагын тухай хууль зэрэг тухайлсан салбарын хуулиуд нь тухайн байгууллагын үйл ажиллагааг зохицуулахад чиглэсэн байдаг бөгөөд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санхүүгийн хэрэглэгчид хүргэхэд тавигдах шаардлагатай холбоотой зохицуулалт байхгүй байна.

Мөн Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос зохицуулалттай этгээдийн санхүүгийн чадварт үндэслэн санхүүгийн системд эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зохистой хяналт шалгалтыг хэрэгжүүлж байгаа бөгөөд санхүүгийн хэрэглэгчид санал болгож, хүргэж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээнд чиглэсэн санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Дээрх зохицуулалтуудыг санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаа зэрэг алхмуудтай зэрэг үр дүнтэй хэрэгжүүлснээр санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалж, санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлнэ.

### **Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, хамрах хүрээ, зохицуулах харилцаа**

Хуулийн төсөл нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санхүүгийн хэрэглэгчид хүргэхэд тавигдах нийтлэг шаардлагыг тогтоох, түүнтэй холбоотой гомдол, маргааныг хянан шийдвэрлэх, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, санхүүгийн хэрэглэгчийн хууль ёсны эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулснаар тус хуулийн зохицуулах харилцаа, хамрах хүрээг тодорхойлох болно. Хуулийн төсөл нь 9 бүлэг, 27 зүйлтэй байх бөгөөд дараах агуулгатай байна:

---

<sup>2</sup> [https://unctad.org/system/files/official-document/cicplpd29\\_en.pdf](https://unctad.org/system/files/official-document/cicplpd29_en.pdf)

1.Хуулийн төслийн нийтлэг үндэслэлд хуулийн зорилт, үйлчлэх хүрээ, хуулийн нэр томъёоны тодорхойлолт болон санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийг хэрэглэх, хэрэгжүүлэх суурь зарчмын талаар тус тус зохицуулах болно.

2.Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь зээл олгохдоо зээлийн бодит өртгийг танилцуулах үүрэгтэй бөгөөд зээлийн бодит өртөг нь зарласан хүү, шимтгэл, хураамж, бусад нэмэлт зардлыг багтаасан дүнг жилийн 365 хоногоор тооцсон хувиар илэрхийлнэ.

3.Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид санхүүгийн хэрэглэгчид төөрөгдүүлэхүйц, бодит бус мэдээлэл өгөх, түгээх, санхүүгийн хэрэглэгчид санхүүгийн үйлчилгээ авах, бусад санхүүгийн үйлчилгээг давхар авах, гэрээ байгуулахыг тулган шаардах, санхүүгийн хэрэглэгчийн санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийг чөлөөтэй сонгох эрхийг хязгаарлах, хууль тогтоомжоор тусгайлан зөвшөөрснөөс бусад тохиолдолд энэ хууль болон бусад хуулиар тогтоосон хариуцлагаас өөрийгөө чөлөөлөх, эсхүл хариуцлагыг хязгаарласан нөхцөлтэй гэрээг санхүүгийн хэрэглэгчтэй байгуулах, гэрээнд зааснаас бусад аливаа хүү, анз, хураамж, шимтгэл, нэмэлт төлбөр шаардахыг зэрэг санхүүгийн хэрэглэгчийн эрх зүйн байдлыг дордуулах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

4.Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь санхүүгийн үйлчилгээний нөхцөл, нийт өртөг, түүний задаргаа, төлбөрийн хуваарь, онцлог, эрсдэл болон үр дагаврын талаарх бүрэн гүйцэд, үнэн зөв, ойлгомжтой, харьцуулж болохуйц мэдээллээр санхүүгийн хэрэглэгчийг хангах, санхүүгийн хэрэглэгчтэй гэрээ байгуулахдаа тухайн гэрээний агуулга, нөхцөл, хүү, хураамж, шимтгэл, нэмэлт төлбөр, тэдгээрийг тооцсон аргачлалыг танилцуулж, тайлбарлах үүрэгтэй. Мөн санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч санхүүгийн хэрэглэгчтэй гэрээ байгуулахдаа эдгээр мэдээллээр хангаснаа нотолж, зохицуулагч байгууллагаас баталсан хяналтын хуудсаар баталгаажуулах ба мэдээллийн ил тод байдлыг хангана.

5.Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч болон санхүүгийн хэрэглэгчийн хоорондын санхүүгийн үйлчилгээний талаарх маргааныг үнэ төлбөргүйгээр түргэн шуурхай, хараат бусаар шийдвэрлэх чиг үүргийг бие даасан, мэргэшсэн санхүүгийн омбудсман хэрэгжүүлж болох бөгөөд түүний эрх зүйн байдал, үйл ажиллагаа, маргаан хянан шийдвэрлэхтэй холбоотой харилцааг тусгайлан тусгана.

6.Зохицуулагч байгууллага нь бусад хуульд заасан чиг үүргээс гадна санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хүрээнд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг зохицуулах, санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтыг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

7.Санхүүгийн хэрэглэгчийн өөрийн хэрэгцээ, шаардлагад тохирсон санхүүгийн үйлчилгээг сонгох, санхүүгийн нөөцийг зохистой удирдах мэдлэг, чадварыг дээшлүүлэх хөтөлбөрийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл болон

боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батлах бөгөөд, уг хөтөлбөрт нийцүүлэн сургалтын агуулга, төлөвлөгөөг зохицуулагч байгууллага болон салбар бүрийн мэргэжлийн холбоод хамтран баталж, хэрэгжүүлнэ.

8.Банк, эрх бүхий хуулийн этгээд болон бусад зээлдүүлэгч этгээд нь зээлдэгчийн орлого, бусад төлбөрийн үүргийг харгалзан зээлдэгчийн төлбөрийн чадварт нийцүүлэн зээл олгож, зээлдүүлэгч зээлийн төлбөр барагдуулахдаа хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх ёс суртахууны хэм хэмжээг баримтлан, зээлдэгчийн хууль ёсны эрх, нэр хүндийг хүндэтгэн, хувийн нууцыг хадгалж, хамгаална.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал**

Хуулийн төсөл батлагдсанаар санхүүгийн хэрэглэгч болон санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч хоорондын мэдээллийн болон эрх, үүргийн тэнцвэртэй байдлыг хангах, улмаар санхүүгийн зах зээлийн үр ашигтай, ил тод, өрсөлдөөнт орчныг бэхжүүлж, иргэдийн санхүүгийн салбарт итгэх итгэлийг нэмэгдүүлэх эерэг үр нөлөөтэй.

Түүнчлэн иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зохицуулагч байгууллагаас зохистой хяналт шалгалтаас гадна санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хяналт шалгалтыг хэрэгжүүлэх замаар санхүүгийн салбарын урт хугацааны хөгжлийг дэмжиж, санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлнэ.

**Гурав.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцтэй болно. Хуулийн төслийг дагалдан гарах Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль болон уг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг тус тус боловсруулан болно.

## ТАНИЛЦУУЛГА

### Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийн талаарх дэлгэрэнгүй танилцуулга

#### Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл, хамрах хүрээ өргөжиж, тэдгээрийг хэрэглэгчид хүргэх суваг улам бүр цахимжиж байгаа өнөөгийн нөхцөлд санхүүгийн хэрэглэгч болон санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн хооронд мэдээлэл, мэргэжлийн мэдлэг, хэлцэл хийх чадавх, нөөц бололцооны тэнцвэргүй байдал илүү тод илэрч байна. Ийм нөхцөлд хэрэглэгчийн эрхийг зөвхөн ерөнхий хэрэглээний эрх зүйн зохицуулалтаар хамгаалах нь санхүүгийн зах зээлийн онцлог, бүтээгдэхүүн, үйлчилгээний эрсдэл, гэрээний нөхцөлийн нарийн төвөгтэй байдал, түүнчлэн үйлчилгээ үзүүлэгчийн мэргэжлийн болон мэдээллийн давамгайл байдлыг бүрэн тусган зохицуулахад хангалтгүй байна.

Монгол Улсад санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбоотой харилцаа Иргэний хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Банкны тухай хууль, Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон санхүүгийн салбарын бусад тусгай хуулиар тодорхой хэмжээнд зохицуулагдаж ирсэн. Гэвч эдгээр зохицуулалт нь ихэвчлэн нийтлэг шинжтэй, эсхүл байгууллагын үйл ажиллагааны зөвшөөрөл, зохистой харьцаа, санхүүгийн чадварын шаардлагад төвлөрсөн тул санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчид санал болгох, тайлбарлах, гэрээ байгуулах, гомдол хянан шийдвэрлэх, хяналт шалгалт хэрэгжүүлэх зэрэг хэрэглэгчийн эрхийн бодит хамгаалалтыг нэгдсэн байдлаар бүрдүүлэх боломжгүйд хүрсэн болно.

Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд 2018 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Монголбанкинд банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиг үүрэг шинээр нэмэгдсэн. Түүнчлэн төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлүүдэд санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, санхүүгийн маргааныг олон улсын сайн туршлагад нийцүүлэн шийдвэрлэх оновчтой тогтолцоо бүрдүүлэх, иргэд болон бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн суурь мэдлэгийг дэмжих зорилтууд тусгагдсан байна. Иймээс Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл нь шинээр дэвшүүлж байгаа зохицуулалт бус, харин өмнө нь тодорхойлсон төрийн бодлого, санхүүгийн зохицуулагч байгууллагын чиг үүргийн өргөжилт, санхүүгийн зах зээлд бодитоор үүссэн хэрэгцээ шаардлагыг хууль зүйн нэгдсэн зохицуулалтад оруулахад чиглэсэн арга хэмжээ юм.

Олон улсын түвшинд 2008 оны дэлхийн санхүүгийн хямрал санхүүгийн хэрэглэгчийн хамгаалалт сул, мэдээллийн ил тод байдал хангалтгүй, хяналт шалгалтын тогтолцоо бүтээгдэхүүн үйлчилгээний зан төлөвт хангалттай чиглээгүй байх нь санхүүгийн тогтвортой

байдалд сөргөөр нөлөөлдөг болохыг харуулсан. Үүний дараа санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тусгай эрх зүйн орчин, хяналт хэрэгжүүлэгч байгууллага, санхүүгийн боловсрол, маргаан шийдвэрлэх хүртээмжтэй тогтолцоог бүрдүүлэх нь олон улсын түгээмэл чиг хандлага болсон.

### **Хоёр.Өнөөгийн нөхцөл байдал, асуудлын мөн чанар**

Тандан судалгаагаар санхүүгийн хэрэглэгчийн эрх зөрчигдөх суурь шалтгаан нь дан ганц хууль зүйн зохицуулалтын дутагдал бус, харин мэдээллийн тэгш бус байдал, гэрээний нөхцөлийг ойлгох боломж хязгаарлагдмал байдал, үйлчилгээ үзүүлэгчийн давамгайл хэлцлийн байр суурь, гомдол маргаан шийдвэрлэх ажиллагааны хүртээмж, зардал, хугацааны хүндрэлтэй шууд холбоотой болох нь тогтоогдсон байна. Санхүүгийн үйлчилгээний гэрээ нь энгийн худалдаа, үйлчилгээний гэрээнээс ялгаатайгаар хүү, шимтгэл, хураамж, нэмэлт төлбөр, эрсдэлийн нөхцөл, хугацааны үүрэг, барьцаа, даатгал, мэдээлэл боловсруулах нөхцөл зэрэг олон бүрэлдэхүүнтэй тул хэрэглэгчийн ойлголт хангалтгүй бол эрх зүйн үр дагавар нь ихэвчлэн хэрэглэгчийн талд хүнд тусдаг.

Банкны салбарын мэдээллээс үзэхэд сүүлийн жилд дотоод аудит болон хяналт шалгалтаар иргэн, аж ахуйн нэгжтэй холбоотой 47 мянган зөрчил илэрсний 99.2 хувь нь иргэдтэй холбоотой байсан боловч банкинд иргэдээс 6.5 мянган өргөдөл, гомдол буюу нийт бүртгэгдсэн зөрчлийн 14 хувьтай тэнцэх хэмжээний гомдол гаргасан байна. Мөн нийт өргөдөл, гомдлын 0.6 хувь нь шүүхээр, 1.4 хувь нь эвлэрүүлэн зуучлагчаар шийдвэрлэгдсэн нь санхүүгийн хэрэглэгчийн хувьд шүүхийн болон бусад маргаан шийдвэрлэх суваг цаг хугацаа, зардал, мэргэжлийн туслалцааны хувьд хүндрэлтэй болохыг харуулж байна.

Хэрэглэгчийн судалгааг Улаанбаатар хот болон 20 аймгийн 3527 иргэний дунд санамсаргүй түүврийн аргаар явуулахад судалгаанд оролцогчдын 50 хувь нь санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар бүрэн мэдээлэл авч чаддаггүй, гурван хүн тутмын нэг нь санхүүгийн үйлчилгээтэй холбоотой хүндрэлтэй тулгарч байсан гэж хариулжээ. Тэдгээр хүндрэлүүдийн 50 хувь нь бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдээлэл дутмаг, зар сурталчилгаа болон ажилтны танилцуулсан мэдээлэл бодит нөхцөлөөс зөрөхтэй холбоотой байсан бөгөөд үлдсэн хэсэг нь дансны хуулга, шимтгэл, хураамж, мэдээллийн нууцлал зэрэг асуудалд хамаарч байна.

Гэрээний харилцаанд мэдээллийн болон хэлцлийн тэнцвэргүй байдал онцгой тод илэрч байна. Судалгаанд хамрагдсан иргэдийн 70 гаруй хувь нь зөвхөн гэрээний ерөнхий мэдээлэл, үйлчилгээ үзүүлэгчийн тайлбарлаж өгсөн мэдээлэлтэй танилцдаг гэж хариулсан бөгөөд гэрээ хэт их мэдээлэл агуулдаг, танилцах хугацаа бага, мэргэжлийн үг хэллэг ихтэй, нөхцөлийг бодитойгоор хэлэлцэх боломж хязгаарлагдмал зэрэг шалтгаан дурдагдсан

байна. Энэ нөхцөл нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэдээлэл өгөх, тайлбарлах, нотлох үүргийг хуульчлах зайлшгүй шаардлагатайг харуулж байна.

## **Гурав.Хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ**

Хуулийн төслийн үндсэн зорилт нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санхүүгийн хэрэглэгчид хүргэхэд тавигдах нийтлэг шаардлагыг тогтоох, түүнтэй холбоотой гомдол, маргааныг хянан шийдвэрлэх, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, санхүүгийн хэрэглэгчийн хууль ёсны эрхийг хамгаалах замаар санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэхэд чиглэж байна.

Тус хуулийн төсөл нь санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ авахаар сонирхож байгаа, эсхүл авсан этгээдийн эрхийг хамгаалах харилцаанд үйлчлэхээр боловсруулагдсан. Харин санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос хуульд заасны дагуу олгосон зөвшөөрөл, бүртгэлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, үнэт цаасны болон даатгалын байгууллага, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч зэрэг зохицуулалттай этгээд хамаарна.

Хуулийн үйлчлэх хүрээ нь санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцаанд төвлөрөх бөгөөд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх харилцаанд уг хууль үйлчлэхгүй байхаар заасан нь зохицуулалтын давхардал, чиг үүргийн зөрчлийг багасгах ач холбогдолтой.

## **Дөрөв.Хуулийн төслийн зохицуулалтын тухайд**

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийн зорилго нь санхүүгийн хэрэглэгчийн хамгаалалтыг зөвхөн иргэний эрхийн асуудал бус, санхүүгийн тогтвортой байдал, зах зээлийн итгэлцэл, шударга өрсөлдөөний асуудал гэдгийг тодотгох нь зүйтэй. Ингэснээр хуулийн төсөл нь салбарын оролцогчдод нэмэлт дарамт бий болгох бус, ил тод, хариуцлагатай зах зээлийн суурь нөхцөлийг бүрдүүлэх бодлогын арга хэмжээ юм.

**4.1.Санхүүгийн хэрэглэгчийн эрх, үүрэг:** Хуулийн төсөл нь санхүүгийн хэрэглэгчийн эрхийг ерөнхий тунхаглалын түвшинд бус, санхүүгийн үйлчилгээ авах бодит харилцаанд хэрэгжихүйц байдлаар тодорхойлж байна. Тухайлбал хэрэглэгч өөрийн санхүүгийн боломж, хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн санхүүгийн үйлчилгээг чөлөөтэй сонгох, үйлчилгээний үнэ, нөхцөл, эрсдэлийн талаар ойлгомжтой, харьцуулж болохуйц мэдээллийг үнэ төлбөргүй авах, маргаан шийдвэрлэх хувилбарыг гэрээнд тусгуулах, эрх ашиг нь зөрчигдсөн бол үйлчилгээ үзүүлэгч болон эрх бүхий маргаан шийдвэрлэх байгууллагад хандах эрхтэй байхаар тусгасан.

Мөн зээлдэгч зээлийн төлбөрийг гэрээгээр тохиролцсон хугацаанаас өмнө нэмэлт торгууль, хураамж, шимтгэлгүйгээр бүхэлд нь болон хэсэгчлэн төлөх эрхтэй байхаар тусгасан нь хэрэглэгчийн санхүүгийн сонголт, өрийн удирдлагын уян хатан байдлыг

нэмэгдүүлэх ач холбогдолтой. Үүнээс гадна гэрээний үүрэг дуусгавар болсноос бусад тохиолдолд санхүүгийн үйлчилгээг авснаас хойш ажлын 10 өдрийн дотор шимтгэл, хураамж, нэмэлт төлбөр, торгуульгүйгээр тухайн үйлчилгээнээс татгалзах, цуцлах эрхийг тусгасан нь олон улсын хэрэглэгчийн хамгаалалтын “cooling-off” зарчмыг нутагшуулсан зохицуулалт болно.

Нөгөө талаас хэрэглэгч үнэн зөв мэдээлэл өгөх, мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд үйлчилгээ үзүүлэгчид шинэчлэн мэдэгдэх, үйлчилгээнээс татгалзсан тохиолдолд ашигласан хугацаанд ногдох үнэ, төлбөрийг төлөх зэрэг үүрэгтэй. Ийнхүү эрх, үүргийг тэнцвэртэй байдлаар тогтоосон нь хэрэглэгчийн хамгаалалтыг үйлчилгээ үзүүлэгчийн хууль ёсны ашиг сонирхолтой зохистой уялдуулж байна.

**4.2. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, хориглох зүйл:** Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн санхүүгийн чадамж, хэрэгцээнд үндэслэн үйлчилгээ үзүүлэх, гэрээ байгуулахаас өмнө гэрээний нөхцөл, хүү, шимтгэл, хураамж, нэмэлт төлбөр, тэдгээрийг тооцох аргачлалыг танилцуулж, тайлбарлах, гомдол хянан шийдвэрлэх дотоод журам, бүтэцтэй байх, хэрэглэгчийн гомдлыг үнэ төлбөргүйгээр шийдвэрлэх, хэрэглэгчийн хувийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хуульд заасны дагуу хангах үүрэгтэй.

Төслийн ач холбогдолтой нэг зохицуулалт нь үйлчилгээ үзүүлэгч мэдээлэл өгснөө нотлох үүрэгтэй байх явдал юм. Санхүүгийн маргаанд хэрэглэгч гэрээний нөхцөл, эрсдэлийг ойлгосон эсэх, үйлчилгээ үзүүлэгч мэдээллээ бүрэн өгсөн эсэх нь гол маргаан болдог. Иймээс гэрээ байгуулахаас өмнөх мэдээлэл өгөх ажиллагааг зохицуулагч байгууллагаас баталсан хяналтын хуудсаар баталгаажуулах зохицуулалт нь нотлох баримтын маргааныг бууруулах, үйлчилгээ үзүүлэгчийн хариуцлагыг бодитой болгох, хяналт шалгалтад шалгах боломжтой баримтын мөр үлдээх давуу талтай.

Хориглох зүйлийн хүрээнд худал, төөрөгдүүлсэн мэдээлэл өгөх, хэрэглэгчийг албадах, хэрэглэгчийн эмзэг байдал, санхүүгийн мэдлэгийн сул талыг ашиглан ашиггүй нөхцөл тулгах, хуульд зааснаас бусад төлбөр, шимтгэл, торгууль ногдуулах зэрэг үйлдлийг хориглох нь шударга, хариуцлагатай санхүүгийн үйлчилгээний үндсэн баталгаа болно.

**4.3. Мэдээллийн ил тод байдал, бодит өртөг:** Хуулийн төсөл санхүүгийн үйлчилгээний нийт өртөг, түүний задаргаа, төлбөрийн хуваарь, бүтээгдэхүүний онцлог, эрсдэл, үр дагаврын талаарх мэдээллийг бүрэн, үнэн зөв, ойлгомжтой, харьцуулж болохуйц байдлаар хэрэглэгчид өгөх шаардлагыг тогтоож байна. Энэ нь хэрэглэгчийн шийдвэр гаргалтад шууд нөлөөлөх суурь мэдээллийг гэрээ байгуулсны дараа бус, гэрээ байгуулахаас өмнө ил тод болгох зорилготой.

Зээлийн бодит өртгийг зарласан хүү, шимтгэл, хураамж болон бусад нэмэлт зардлыг багтаасан дүнг жилийн 365 хоногоор тооцсон хувиар илэрхийлэхээр тодорхойлсон нь бүтээгдэхүүн хоорондын харьцуулалт хийх боломжийг нэмэгдүүлнэ. Зөвхөн нэрлэсэн хүүг мэдээлэх нь хэрэглэгчид зээлийн нийт өртгийг буруу үнэлэх

эрсдэлтэй тул бодит өртгийн ил тод байдал нь нуугдмал төлбөр, шимтгэл, хураамжийн эрсдэлийг багасгах гол хэрэгсэл болно.

**4.4.Гомдол, маргаан шийдвэрлэх тогтолцоо:** Хуулийн төсөл санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн дотоод гомдол шийдвэрлэх тогтолцоог эхний шатны зайлшгүй механизм болгон төлөвлөжээ. Үйлчилгээ үзүүлэгч нь гомдлыг амаар, утсаар, бичгээр, цахим шуудан болон цахим хуудсаар үнэ төлбөргүй хүлээн авах, тогтоосон хугацаанд шийдвэрлэх, шийдвэрийн талаар хэрэглэгчид бичгээр эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэх үүрэгтэй.

Дотоод гомдол шийдвэрлэх ажиллагаа үр дүнгүй болсон, эсхүл тогтоосон хугацаанд гомдлыг шийдвэрлээгүй тохиолдолд санхүүгийн хэрэглэгч Санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллагад хандах боломжтой байхаар тусгасан. Энэ байгууллага нь Удирдах зөвлөл, омбудсман болон ажлын албанаас бүрдэх бөгөөд маргааныг үнэ төлбөргүй, түргэн шуурхай, хараат бус, мэргэшсэн байдлаар шийдвэрлэх чиг үүрэгтэй байх үзэл баримтлалтай байна. Шүүхийн ажиллагааны зардал, хугацааны хүндрэл өндөр байдаг нөхцөлд омбудсманы тогтолцоо нь хэрэглэгчийн эрхийг бодитой хамгаалах, жижиг дүнтэй боловч өргөн хүрээтэй маргааныг үр ашигтай шийдвэрлэх чухал институцийн шийдэл болно.

Санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллагын эхлэлтийн санхүүжилтийг Монголбанкнаас бүрдүүлэх, цаашид санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийн жилийн хураамж, үйлчилгээний шимтгэл болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэхээр тусгасан нь байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах зорилготой. Гэхдээ тус байгууллагын хараат бус байдал, санхүүжилтийн эх үүсвэр, шийдвэрийн биелэлт, шүүхийн хяналтын хүрээ зэрэг асуудлыг хэрэгжилтийн шатанд нарийвчлан зохицуулах шаардлагатай.

**4.5.Санхүүгийн боловсрол, хэрэглэгчийн чадавх:** Хуулийн төсөл санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудлыг зөвхөн гомдол шийдвэрлэх болон хяналт шалгалтын хүрээнд бус, урьдчилан сэргийлэх бодлогын түвшинд авч үзсэн. Санхүүгийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагааг олон нийтийн санхүүгийн мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ гэж тодорхойлж, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран хөтөлбөр батлах, зохицуулагч байгууллага болон салбарын мэргэжлийн холбоод сургалтын агуулга, төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр тусгасан.

Энэ зохицуулалтын бодлогын ач холбогдол нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах, санхүүгийн зах зээлд итгэх итгэл, өрхийн санхүүгийн сахилга бат, зээлийн хариуцлагатай хэрэглээ, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэг бодлогын хүрээнд холбож байгаад оршино. Санхүүгийн боловсрол нэмэгдэх нь хэрэглэгчийн сонголтын чанарыг сайжруулж, үйлчилгээ үзүүлэгчийн өрсөлдөөн бүтээгдэхүүний чанар, ил тод байдалд суурилах нөхцөлийг бүрдүүлнэ.

**4.6.Зохицуулагч байгууллагын бүрэн эрх, хяналт шалгалт:** Зохицуулагч байгууллага буюу Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо нь тус хуулийн хэрэгжилтийг

хангуулах, санхүүгийн боловсрол дээшлүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн зан төлөвийг үнэлэх, бусад эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах бүрэн эрхтэй байхаар тусгасан байна.

Энэхүү зохицуулалт нь зохистой харьцаа, санхүүгийн чадварт төвлөрсөн уламжлалт хяналтаас гадна хэрэглэгчтэй харьцах зан төлөв, бүтээгдэхүүн үйлчилгээний ил тод байдал, гэрээний шударга нөхцөл, гомдол шийдвэрлэлт зэрэг “market conduct supervision” буюу зах зээлийн зан төлөвийн хяналтыг бие даасан чиг үүрэг болгон хуульчилж байгаагаараа онцлог юм. Хуулийн төсөлд зохицуулагч байгууллага санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалт болон санхүүгийн боловсролын чиг үүрэг бүхий бие даасан нэгж, орон тоотой байхаар заасан нь хэрэгжилтийн институцийн чадавхыг хангах суурь нөхцөл болно.

Зохицуулагч байгууллага хууль зөрчсөн тохиолдолд алдааг арилгуулах, буруу ташаа мэдээлэл, зар сурталчилгааг залруулахыг шаардах, тодорхой санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийг хэсэгчлэн болон бүхэлд нь хязгаарлах, түдгэлзүүлэх, зогсоох, зөвшөөрлийг хуульд заасан журмаар түдгэлзүүлэх, хүчингүй болгох зэрэг арга хэмжээ авах боломжтой байхаар тусгасан. Энэ нь хэрэглэгчийн эрх зөрчигдсөний дараах эрхийг сэргээх арга хэмжээ төдийгүй, зах зээлийн нийт оролцогчдод урьдчилан сэргийлэх дохио өгөх зохицуулалтын ач холбогдолтой.

### **Тав.Шударга бус зээл, хэт түрэмгий нөхцөлийн эсрэг зохицуулалт**

Тандан судалгаанд дурдсан “өдрийн зээл”, өндөр хүүтэй богино хугацааны зээл, нуугдмал шимтгэл, тодорхой бус нөхцөл, зээлдэгчийн төлбөрийн чадвараас давсан зээлийн эрсдэл нь санхүүгийн хэрэглэгчийн хамгаалалтын нэг гол асуудал болохыг харуулж байна. Хэт түрэмгий нөхцөл бүхий зээл нь ихэвчлэн зээлдүүлэгчид илүү ашигтай боловч зээлдэгчийн санхүүгийн эмзэг байдал, мэдээллийн дутагдал, яаралтай хэрэгцээг ашиглах шинжтэй байдаг.

Хуулийн төсөлд банк, эрх бүхий хуулийн этгээд болон бусад зээлдүүлэгч этгээд зээлдэгчийн орлого, бусад төлбөрийн үүргийг харгалзан төлбөрийн чадварт нийцүүлэн зээл олгохоор тусгасан нь хариуцлагатай зээлийн зарчмыг хуульчлах чиглэлд ач холбогдолтой. Ийнхүү зээл олгох ажиллагаанд төлбөрийн чадварын үнэлгээ, бодит өртгийн ил тод байдал, гэрээний нөхцөлийн тайлбар, хяналтын хуудас, гомдол шийдвэрлэх механизм зэрэг зохицуулалт зэрэгцэн үйлчилснээр хэрэглэгчийг нуугдмал өртөгтэй, шударга бус, төлбөрийн чадвараас давсан зээлийн эрсдэлээс хамгаалах боломж бүрдэнэ.

### **Зургаа.Хуулийн төслийн үр нөлөө, хэрэгжих боломж**

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээнд зорилгод хүрэх байдал, практикт хэрэгжих боломж, хүлээн зөвшөөрөгдөх байдал, ойлгомжтой байдал, харилцан уялдаа гэсэн үндсэн шалгуур үзүүлэлтийг сонгон дүн шинжилгээ хийсэн байна. Үнэлгээний дүгнэлтээр хуулийн төсөл нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчид хүргэхэд

тавигдах нийтлэг шаардлагыг тогтоох, олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах замаар санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх зорилгодоо хүрэх боломжтой.

Практикт хэрэгжих боломжийн хувьд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо 2018 оноос Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах төсөл хэрэгжүүлж, олон улсын туршлага судлах, зохицуулагч байгууллагын хяналт шалгалтын чадамжийг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт, зөвлөмж авч ирсэн нь хууль хэрэгжүүлэх урьдчилсан бэлтгэлийг тодорхой хэмжээнд бүрдүүлсэн байна. Гэхдээ хууль батлагдсаны дараа зохицуулагч байгууллагын дотоод бүтэц, хүний нөөц, аргачлал, хяналтын хуудас, тайлагналын стандарт, мэдээллийн системийг богино хугацаанд бэлэн болгох шаардлага хэвээр байна.

### Хэрэгжилтийн бэлтгэлд анхаарах асуудал

Чиглэл	Анхаарах асуудал	Хэрэгжүүлэх боломжит арга хэмжээ
Хяналт шалгалт	Зах зээлийн зан төлөвийн хяналт нь зохистой харьцааны хяналт шалгалтаас өөр аргачлал шаарддаг.	Эрсдэлд суурилсан санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтын аргачлал, шалгах хуудас, тайлангийн загвар батлах.
Мэдээллийн ил тод байдал	Бодит өртөг, нийт өртөг, шимтгэл, хураамжийн мэдээлэл бүтээгдэхүүн бүрээр харилцан адилгүй байна.	Бүтээгдэхүүн тус бүрийн стандарт мэдээллийн хуудас, өртөг тооцох аргачлал, хэрэглэгчид өгөх тайлбарын загвар боловсруулах.
Омбудсман	Хараат бус байдал, санхүүжилт, шийдвэрийн биелэлт, шүүхийн хяналтын хүрээ тодорхой байх шаардлагатай.	Санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллагын дүрэм, журам, маргаан хянан шийдвэрлэх процесс, тайлагналын механизмыг нарийвчлах.
Санхүүгийн боловсрол	Сургалтын агуулга салбар бүрийн бүтээгдэхүүний эрсдэлтэй уялдах шаардлагатай.	Сургууль, олон нийт, ЖДҮ, ахмад настан, цахим үйлчилгээ хэрэглэгч зэрэг зорилтот бүлгээр ялгасан хөтөлбөр хэрэгжүүлэх.
Шилжилтийн зохицуулалт	Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийн гэрээ, журам, мэдээллийн системийг шинэчлэх хугацаа шаардагдана.	Хэрэгжилтийн хугацаа, дотоод журам шинэчлэх үүрэг, зохицуулагчид тайлагнах төлөвлөгөөг шаталсан байдлаар тогтоох.

### Долоо.Хуулийн төслийн бодлогын ач холбогдол

Хуулийн төсөл батлагдсанаар санхүүгийн хэрэглэгч болон санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн хоорондын мэдээллийн болон хэлцлийн тэнцвэргүй байдлыг бууруулах, санхүүгийн үйлчилгээний ил тод, хариуцлагатай, мэргэжлийн стандартыг бэхжүүлэх, санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх бодлогын үр нөлөөтэй байна.

Нэгдүгээрт, хэрэглэгч санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ, нөхцөл, эрсдэлийн талаар харьцуулж болохуйц мэдээлэл авах эрхтэй болж, үйлчилгээ үзүүлэгч энэ мэдээллийг өгсөн, тайлбарласан гэдгээ нотлох үүрэгтэй болно. Энэ нь хэрэглэгчийн сонголтыг бодит мэдээлэлд суурилуулах бөгөөд үйлчилгээ үзүүлэгчдийн өрсөлдөөн зөвхөн хүү, шимтгэлээр бус үйлчилгээний чанар, ил тод байдал, шударга нөхцөлөөр хэмжигдэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Хоёрдугаарт, гомдол, маргаан шийдвэрлэх шаталсан, мэргэшсэн тогтолцоо бүрдсэнээр хэрэглэгчийн эрх хамгаалуулах бодит боломж нэмэгдэнэ. Дотоод гомдол шийдвэрлэх ажиллагаа үйлчилгээ үзүүлэгчийн хариуцлагыг сайжруулах бол санхүүгийн омбудсманы шинжтэй механизм нь шүүхийн ачаалал, хэрэглэгчийн зардал, маргаан шийдвэрлэх хугацааг бууруулах боломжтой.

Гуравдугаарт, зохицуулагч байгууллагын бүрэн эрх санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн зан төлөв, бүтээгдэхүүн үйлчилгээний ил тод байдал, гомдол шийдвэрлэлт, хэрэглэгчийн мэдээллийн хамгаалалт зэрэгт чиглэх тул санхүүгийн салбарын хяналт илүү иж бүрэн болно. Энэ нь зөвхөн нэг хэрэглэгчийн эрхийг хамгаалах бус, зах зээлийн сахилга бат, салбарын тогтвортой байдал, итгэлцлийг дээшлүүлэх өргөн үр нөлөөтэй.

Дөрөвдүгээрт, санхүүгийн боловсролыг хуулийн бодлогын бүрэлдэхүүн хэсэг болгон тусгаснаар хэрэглэгчийн эрх хамгаалалт гомдол гарсны дараах арга хэмжээгээр хязгаарлагдахгүй, урьдчилан сэргийлэх, мэдээлэлд суурилсан сонголтыг дэмжих тогтолцоонд шилжинэ.

### **Найм.Хууль тогтоомж, олон улсын нийтлэг зарчимтай нийцэх байдал**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон санхүүгийн салбарын холбогдох хууль тогтоомжтой нийцтэй байдлаар боловсруулагдсан болно.

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах олон улсын сайн туршлага нь хэд хэдэн нийтлэг тулгуур зарчимд суурилдаг. Үүнд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөл, өртөг, эрсдэлийг гэрээ байгуулахаас өмнө ойлгомжтой мэдээлэх; хэрэглэгчийн хувийн мэдээлэл, нууцлалыг хамгаалах; хариуцлагатай зээл олголт, шударга бус гэрээний нөхцөлийг хориглох; санхүүгийн боловсролыг бодлогын түвшинд дэмжих; хямд, хүртээмжтэй, мэргэшсэн маргаан шийдвэрлэх механизмтай байх; зохицуулагч байгууллага зах зээлийн зан төлөвт чиглэсэн хяналт шалгалт хэрэгжүүлэх зэрэг багтана.

Төсөлд туссан мэдээллийн ил тод байдал, бодит өртгийн тооцоолол, гэрээ байгуулахаас өмнөх тайлбар, хяналтын хуудас, дотоод гомдол шийдвэрлэх журам, санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллага, санхүүгийн боловсролын хөтөлбөр,

зохицуулагчийн бүрэн эрхийн зохицуулалт нь дээрх олон улсын зарчимтай нийцэж байна. Ялангуяа санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтыг зохистой хяналтаас ялган бие даасан чиг үүрэг болгох нь хэрэглэгчийн эрхийн хамгаалалтыг байгууллагын санхүүгийн чадварын хяналтаас давуулан бүтээгдэхүүн, үйлчилгээний бодит зан төлөвт чиглүүлэх ач холбогдолтой.

## **Ес.Дүгнэлт**

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл нь Монгол Улсад санхүүгийн хэрэглэгчийн эрхийг тусгайлан, салбар дамнасан, хэрэгжихүйц байдлаар хамгаалах эрх зүйн суурийг бүрдүүлэх ач холбогдолтой. Одоогийн зохицуулалт хэрэглэгчийн эрхийг ерөнхий түвшинд хамгаалж байгаа боловч санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний онцлог, гэрээний нарийн төвөгтэй байдал, мэдээллийн тэгш бус байдал, гомдол маргаан шийдвэрлэх хүндрэл, зохицуулагчийн зан төлөвийн хяналтын хэрэгцээг бүрэн хангахгүй байна.

Тандан судалгаагаар илэрсэн тоон мэдээлэл, хэрэглэгчийн судалгааны дүн, олон улсын сайн туршлага, Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооны хэрэгжүүлж ирсэн бэлтгэл ажил, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний дүгнэлтүүдийг нэгтгэн үзвэл санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тусгай хуулийг батлах бодит хэрэгцээ, шаардлага бүрдсэн байна.

Хуулийн төсөл батлагдсанаар санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэдээлэл өгөх, тайлбарлах, нотлох, гомдол шийдвэрлэх, хариуцлагатай үйлчилгээ үзүүлэх үүрэг тодорхой болж, хэрэглэгчийн сонголт, маргаан шийдвэрлүүлэх боломж, санхүүгийн боловсролын бодлого, зохицуулагч байгууллагын хяналт шалгалтын бүрэн эрх шинэ түвшинд гарна.

## ТАНИЛЦУУЛГА

### Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийн талаар

2018 онд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон Азийн хөгжлийн банк хооронд “Харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулж “Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах” төслийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд төслийн хүрээнд санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль эрх зүйн тогтолцооны талаар олон улсын туршлага судлах, иргэдийн санхүүгийн мэдлэг, зохицуулагч байгууллагын хяналт шалгалтын чадамжийн дээшлүүлэх чиглэлээр олон удаагийн сургалт зохион байгуулж ажиллалаа.

Мөн Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос хамтран төслийн зөвлөхөөс өгсөн санал, зөвлөмжийг үндэслэн Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс үзүүлж байгаа санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлагыг тогтоож, зохицуулагч байгууллагаас зохистой хяналт шалгалтаас гадна санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх агуулгаар боловсруулсан болно.

Хуулийн төсөл нь “санхүүгийн хэрэглэгч” буюу санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ авахаар сонирхож байгаа, эсхүл авсан хувь хүний эрхийг хамгаалахад чиглэгдсэн болно. Харин санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид зохицуулагч байгууллага болох Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон зөвшөөрөл, бүртгэлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийг хамааруулсан. Өөрөөр хэлбэл тус хууль нь банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, үнэт цаас, даатгалын компаниуд, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч зэрэг этгээдүүдэд хамаарна.

Хуулийн төсөлд тусгагдсан зарим зохицуулалтуудаас дурдвал:

1. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь санхүүгийн үйлчилгээний нөхцөл, нийт өртөг, түүний задаргаа, төлбөрийн хуваарь, онцлог, эрсдэл болон үр дагаврын талаарх бүрэн гүйцэд, үнэн зөв, ойлгомжтой, харьцуулж болохуйц мэдээллээр санхүүгийн хэрэглэгчийг хангах, санхүүгийн хэрэглэгчтэй гэрээ байгуулахдаа тухайн гэрээний агуулга, нөхцөл, хүү, хураамж, шимтгэл, нэмэлт

төлбөр, тэдгээрийг тооцсон аргачлалыг танилцуулж, тайлбарлах үүрэгтэй. Мөн санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч санхүүгийн хэрэглэгчтэй гэрээ байгуулахдаа эдгээр мэдээллээр хангаснаа нотолж, зохицуулагч байгууллагаас баталсан хяналтын хуудсаар баталгаажуулна.

2. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь зээл олгохдоо зээлийн бодит өртгийг танилцуулах үүрэгтэй бөгөөд зээлийн бодит өртөг нь зарласан хүү, шимтгэл, хураамж, бусад нэмэлт зардлыг багтаасан дүнг жилийн 365 хоногоор тооцсон хувиар илэрхийлсэн үзүүлэлт байна.

3. Зохицуулагч байгууллага нь бусад хуульд заасан чиг үүргээс гадна санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хүрээнд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг зохицуулах, санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байна.

4. Санхүүгийн хэрэглэгчийн өөрийн хэрэгцээ, шаардлагад тохирсон санхүүгийн үйлчилгээг сонгох, санхүүгийн нөөцийг зохистой удирдах мэдлэг, чадварыг дээшлүүлэх хөтөлбөрийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батлах бөгөөд, уг хөтөлбөрт нийцүүлэн сургалтын агуулга, төлөвлөгөөг зохицуулагч байгууллага болон салбар бүрийн мэргэжлийн холбоод хамтран баталж, хэрэгжүүлнэ. Мөн санхүүгийн хэрэглэгч нь өөрийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, бие даан сурахыг эрмэлзэнэ.

5. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч болон санхүүгийн хэрэглэгчийн хоорондын санхүүгийн үйлчилгээний талаарх маргааныг үнэ төлбөргүйгээр түргэн шуурхай, хараат бусаар шийдвэрлэх чиг үүргийг бие даасан, мэргэшсэн санхүүгийн омбудсман хэрэгжүүлж болох бөгөөд түүний эрх зүйн байдал, үйл ажиллагаа, маргаан хянан шийдвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газар болон Монголбанкны Хяналт шалгалт газар болон бусад чиг үүргийн нэгж нь тус тус хөрөнгө оруулагч, харилцагч хадгаламж эзэмшигч, зээлдэгч болон санхүүгийн хэрэглэгч нараас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянаж, санал дүгнэлт гарган хуульд заасан эрх хэмжээний хүрээнд урьдчилан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Санхүүгийн зохицуулах хороо нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Банк бус

санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль зэрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгө оруулагч үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг. Санхүүгийн зохицуулах хороо нь 2025 оны эхний хагас жилийн байдлаар албан бичгээр 401, цахимаар 135, Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан ирүүлсэн 70, нийт 606 өргөдөл, гомдол ирүүлснийг хүлээн авч 555 өргөдөл, гомдлыг хянаж шийдвэрлэн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласан бол 51 өргөдөл, гомдол хуулийн хугацаанд хянагдаж байна.

*Нийт өргөдөл гомдлын тоо (салбараар)*

№	Салбар	2022.IV	2023.IV	2024.IV	2025.II				
					Албан бичиг	Info	11-11 төв	Нийт	Эзлэх хувь
1	Даатгал	257	453	475	162	90	43	295	49.0%
2	Үнэт цаас	135	121	137	60	4	16	80	13.0%
3	ББСБ	140	172	140	92	30	5	127	21.0%
4	ХЗХ	20	14	29	25	-	-	25	4.0%
5	Мөнгөн зээлийн үйл ажиллагаа	-	-	25	26	4	1	31	5.1%
6	ВХҮҮ	-	-	24	-	6	3	9	1.5%
7	Бусад	77	128	24	36	1	2	39	6.4%
<b>Нийт</b>		<b>629</b>	<b>888</b>	<b>854</b>	<b>401</b>	<b>135</b>	<b>70</b>	<b>606</b>	<b>100%</b>

Монголбанкнаас Банкны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах замаар банкны харилцагчдын эрх ашгийг хамгаалах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд харилцагч, хадгаламж эзэмшигчийн өргөдөл гомдлыг хүлээн авч, шийдвэрлэдэг.

№	Өргөдөл	2020 III, IV	2021	2022 I, II	2023	2024, III	2025, I	2025, II
1	Иргэн	84	115	56	54	44	46	42
2	ААН	18	23	15	25	12	8	7
<b>Нийт</b>		<b>102</b>	<b>138</b>	<b>71</b>	<b>79</b>	<b>56</b>	<b>54</b>	<b>49</b>

Банкны үйл ажиллагаатай холбоотойгоор 2024 оны эхний 3 удирлын байдлаар авч үзэхэд ирүүлсэн ирүүлсэн өргөдөл, гомдлын 21.4 хувь нь зээлийн

гэрээний маргаантай холбоотой байсан бол 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 45.4 хувь нь зээлийн ангилалтай холбоотой байна.

№	Товч утга	2020 III, IV	Эзлэх хувь	2021	Эзлэх хувь	2022 I, II	Эзлэх хувь	2023	Эзлэх хувь	2024 III	Эзлэх хувь	2025.I	Эзлэх хувь	2025.II	Эзлэх хувь
1	Зээлийн гэрээний маргаан	28	27.5%	41	29.7%	23	32.4%	12	15.1%	12	21.4%	8	14.51%	8	16.3%
2	Зээлийн ангилалтай холбоотой	13	12.7%	10	7.2%	4	5.6%	16	20.2%	9	16%	25	45.41%	25	51%
3	Хадгаламжийн гэрээний маргаан	7	6.9%	7	5.1%	5	7%	5	6.3%	4	7.1%	2	3.61%		
4	Ковид-19-ээс үүдсэн гэрээний маргаан	10	9.8%	26	18.8%	1	1%	3	3.7%	1	1.7%	-			
5	Дансны гүйлгээ болон битүүмж							10	12.6%	8	14.2%	3	5.41%	6	12.2%
6	Бусад	44	43.1%	54	39.1%	38	38%	33	41.7%	22	39.2%	17	30.91%	10	20.4%
<b>Нийт</b>		<b>102</b>		<b>138</b>		<b>71</b>		<b>79</b>		<b>56</b>		<b>55</b>		<b>49</b>	

*Банктай холбоотой өргөдөл гомдлын шийдвэрлэлт*

№	Өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн байдал	2020 III, IV	2021	2022 I, II	2023	2024.III	2025.I, II
1	Албан бичгээр хариу өгсөн	76	87	46	43	37	53
2	Утсаар хариу өгсөн	22	43	20	28	15	48
3	Улсын байцаагчийн акт, мэдэгдэл хүргүүлж шийдвэрлэсэн	1		1	1	3	2
4	Бусад байдлаар (зөрчлийн хэрэг нээж хялбаршуулсан журмаар, цахим шуудан)	3	8	4	7	1	1
<b>Нийт</b>		<b>102</b>	<b>138</b>	<b>71</b>	<b>79</b>	<b>56</b>	<b>104</b>

Нэгдсэн Үндэсний байгууллага (НҮБ)-аас дэлхийн санхүүгийн зах зээл дээр үүссэн 2008 оны хямрал нь "санхүүгийн хэрэглэгч"-ийн эрх ашгийг хамгаалах үр дүнтэй арга хэмжээ дутмаг байгааг харуулсан сургамж болсоныг дүгнэсэн байдаг. Энэ нь улс орнууд санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах

хууль тогтоомж, бодлого хэрэгжүүлэгч агентлагуудыг бий болгоход түлхэц болсон. Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалахад хууль, эрх зүйн акт боловсруулах, зохицуулагч байгууллага болон хяналт шалгалтын тогтолцоо байх ёстой гэж үзсэн.

НҮБ-ын Ерөнхий Ассамблей санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах шинэчилсэн удирдамжийг батлахаар шийдвэрлэсэн бөгөөд үүнд санхүүгийн үйлчилгээний тухай шинэ зохицуулалт, хэрэгжилт, хяналт, санхүүгийн хэрэглэгчийн боловсрол болон санхүүгийн мэдлэг, мэдээллийг ил тод байдал, хариуцлагатай бизнесийн үйл ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдлын хамгаалалт зэрэг шинээр гарч ирж буй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ зэрэг асуудлуудыг шийдвэрлэхээр тусгасан. Тодруулбал:

- Санхүүгийн үйлчилгээнд хэрэглэгчийн эрхийг хамгаалах зохих эрх зүйн зохицуулалтыг баталж, тогтмол шинэчлэх;
- Хууль сахиулах байгууллага, хяналтын байгууллагыг байгуулж, шаардлагатай эрх мэдэл, нөөцөөр хангах;
- Мэдээллийн ил тод байдал, санхүүгийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, хэрэглэгчийн хувийн нууцыг хамгаалах, болон маргаан шийдвэрлэх боломж;
- Санхүүгийн үйлчилгээний хүртээмж, олон талт стратегийг боловсруулж хэрэгжүүлэх;
- Дампуурлыг арилгах үр дүнтэй бодлого хэрэгжүүлэх гэх мэт санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах талаар бодлогын зөвлөмжүүдийг тусгасан бөгөөд гишүүн орнууддаа дагаж мөрдөхийг зөвлөсөн байна.

Хуулийн төсөл батлагдсанаар санхүүгийн хэрэглэгч болон санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч хоорондын мэдээллийн болон эрх, үүргийн тэнцвэртэй байдлыг хангах, улмаар санхүүгийн зах зээлийн үр ашигтай, ил тод, өрсөлдөөнт орчныг бэхжүүлж, иргэдийн санхүүгийн салбарт итгэх итгэлийг нэмэгдүүлэх эерэг үр нөлөөтэй гэж үзэж байна. Түүнчлэн иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зохицуулагч байгууллагаас зохистой хяналт шалгалтаас гадна санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хяналт шалгалтыг хэрэгжүүлэх замаар санхүүгийн салбарын урт хугацааны хөгжлийг дэмжиж, санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлнэ.

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2026 оны ... дугаар  
сарын ... өдөр

Улаанбаатар хот

**САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН  
ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санхүүгийн хэрэглэгчид хүргэхэд тавигдах нийтлэг шаардлагыг тогтоох, түүнтэй холбоотой гомдол, маргааныг хянан шийдвэрлэх, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, санхүүгийн хэрэглэгчийн хууль ёсны эрхийг хамгаалах замаар санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэхэд оршино.

**2 дугаар зүйл.Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль тогтоомж**

2.1.Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1.Энэ хуулиар санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ авахаар сонирхож байгаа, эсхүл авсан санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулна.

3.2.Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд энэ хууль хамаарахгүй.

**4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."санхүүгийн хэрэглэгч" гэж санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ авахаар сонирхож байгаа, эсхүл авсан этгээдийг;

4.1.2."санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч" гэж зохицуулагч байгууллагаас хуульд заасны дагуу олгосон зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийг;

4.1.3."санхүүгийн үйлчилгээ" гэж санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс санхүүгийн хэрэглэгчид санал болгож, нийлүүлж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээг;

4.1.4."санхүүгийн боловсрол" гэж санхүүгийн хэрэглэгч өөрийн хэрэгцээ, шаардлагад тохирсон санхүүгийн үйлчилгээг сонгох, санхүүгийн нөөцийг зохистой удирдах мэдлэг, чадварыг;

4.1.5."санхүүгийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагаа" гэж олон нийтэд санхүүгийн боловсрол олгох, дээшлүүлэх цогц арга хэмжээг;

4.1.6."хариуцлагатай санхүүгийн үйлчилгээ" гэж санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийг;

4.1.7."санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалт" гэж Зохицуулагч байгууллагаас өөрийн хянан зохицуулах чиг үүргийн хүрээнд энэ хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор хийх хяналт шалгалтын бие даасан цогц арга хэмжээг;

4.1.8."зохицуулагч байгууллага" гэж Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороог;

4.1.9."санхүүгийн үйлчилгээний бодит өртөг" гэж санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс санал болгож байгаа тухайн санхүүгийн үйлчилгээний нийт зардлыг багтаасан санхүүгийн хэрэглэгчээс гарах дүнг;

4.1.10."зээлийн бодит өртөг" гэж зарласан хүү, шимтгэл, хураамж, бусад нэмэлт зардлыг багтаасан дүнг жилийн 365 хоногоор тооцсон хувиар илэрхийлсэн үзүүлэлтийг.

## **5 дугаар зүйл.Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаандаа баримтлах зарчим**

5.1.Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

5.1.1.ил тод байх;

5.1.2.санхүүгийн хэрэглэгчид чөлөөт сонголт хийх боломжийг олгох;

5.1.3.гомдлыг шуурхай шийдвэрлэх тогтолцоотой байх;

5.1.4.хариуцлагатай, мэргэжлийн ёс зүйтэй байх;

5.1.5.мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах;

5.1.6.санхүүгийн үйлчилгээ нь санхүүгийн хэрэглэгчийн ашиг сонирхолд нийцсэн, хүртээмжтэй байх;

5.1.7.олон нийтийн санхүүгийн боловсролыг дэмжих.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

### **6 дугаар зүйл.Санхүүгийн хэрэглэгчийн эрх**

6.1.Санхүүгийн хэрэглэгч нь бусад хууль тогтоомжид зааснаас гадна дараах эрхтэй:

6.1.1.санхүүгийн үйлчилгээг өөрийн санхүүгийн боломж, хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн чөлөөтэй сонгох;

6.1.2.санхүүгийн үйлчилгээний үнэ, нөхцөл, эрсдэлийн талаар ойлгомжтой, харьцуулж болохуйц мэдээллийг үнэ төлбөргүйгээр авах;

6.1.3.талуудын хооронд үүсэж болох маргааныг шийдвэрлэх хувилбарын тухай саналаа гэрээнд тусгахыг шаардах;

6.1.4.хууль ёсны эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзвэл санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч, хуульд заасан маргаан шийдвэрлэх эрх бүхий байгууллагад хандан гомдол, маргаанаа шийдвэрлүүлэх;

6.1.5.зээлийн төлбөрийг зээлийн гэрээгээр тохиролцсон хугацаанаас өмнө нэмэлт торгууль, нэмэлт хураамж, шимтгэл, төлбөргүйгээр бүхэлд нь болон хэсэгчлэн төлөх;

6.1.6.гэрээ, хэлцлээр тохиролцсон үүрэг дуусгавар болсноос бусад тохиолдолд санхүүгийн үйлчилгээг авснаас хойш ажлын 10 өдрийн дотор шимтгэл, хураамж, нэмэлт төлбөр, торгуульгүйгээр тухайн үйлчилгээнээс татгалзах, цуцлах;

### **7 дугаар зүйл.Санхүүгийн хэрэглэгчийн үүрэг**

7.1.Санхүүгийн хэрэглэгч нь бусад хууль тогтоомжид зааснаас гадна дараах үүргийг хүлээнэ:

7.1.1.санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс санхүүгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан хуульд заасны дагуу шаардсан мэдээллийг үнэн зөвөөр мэдээлэх;

7.1.2.энэ хуулийн 7.1.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт орсон нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээнд үр дагавар үүсгэхээр бол тухайн мэдээллийг тухай бүр шинэчлэн санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид гаргаж өгөх;

7.1.3.хуульд заасан маргаан шийдвэрлэх эрх бүхий байгууллагад гомдол гаргасан өдрөөс эхлэн маргаан шийдвэрлэх хүртэлх хугацаанд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс хохирол барагдуулахыг шаардахгүй байх;

7.1.4.энэ хуулийн 6.1.6-д заасан тохиолдолд тухайн үйлчилгээг авснаас хойших ашигласан хугацаанд ногдох санхүүгийн үйлчилгээний үнэ, төлбөрийг санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид төлөх;

7.2.Санхүүгийн хэрэглэгч нь энэхүү үүргийг биелүүлээгүй, эсхүл санаатайгаар худал, төөрөгдүүлсэн мэдээлэл өгсөн тохиолдолд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь хуульд заасан журмын дагуу үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, үйлчилгээний хүрээг хязгаарлах, харилцааг зогсоох арга хэмжээ авах үндэслэл болно.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ҮҮРЭГ БА ХОРИГЛОХ ЗҮЙЛ**

### **8 дугаар зүйл.Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг**

8.1.Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь бусад хууль тогтоомжид зааснаас гадна дараах үүргийг хүлээнэ:

8.1.1.санхүүгийн хэрэглэгчийн санхүүгийн чадамж, хэрэгцээнд үндэслэн санхүүгийн үйлчилгээ үзүүлэх;

8.1.2.гэрээнд өөрчлөлт оруулах санал гаргах, гэрээнээс татгалзах, цуцлах эрхтэй болохыг гэрээ байгуулахаас өмнө санхүүгийн хэрэглэгчид танилцуулах;

8.1.3.санхүүгийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзсан тохиолдолд үндэслэл бүхий тайлбарыг санхүүгийн хэрэглэгчид мэдэгдэх;

8.1.4.санхүүгийн хэрэглэгчтэй гэрээ байгуулахдаа тухайн гэрээний агуулга, нөхцөл, хүү, хураамж, шимтгэл, нэмэлт төлбөр, тэдгээрийг тооцсон аргачлалыг танилцуулж, тайлбарлах;

8.1.5.санхүүгийн хэрэглэгчтэй харилцах, гомдлыг хянан шийдвэрлэх дотоод журам, бүтэцтэй байх;

8.1.6.санхүүгийн хэрэглэгчийн гомдлыг энэ хуульд заасан хугацаанд үнэ төлбөргүйгээр шийдвэрлэж, шийдвэрийн талаар санхүүгийн хэрэглэгчид бичгээр эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэх;

8.1.7.санхүүгийн хэрэглэгчийн гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн тухай нэгдсэн тайлан, мэдээг тогтоосон хугацаанд зохицуулагч байгууллагад хүргүүлж, өөрийн цахим хуудсанд байршуулах;

8.1.8.санхүүгийн хэрэглэгчид хохирол учруулсан нь маргаан шийдвэрлэх эрх бүхий байгууллагаас тогтоогдсон тохиолдолд хохирлыг барагдуулах;

8.1.9.санхүүгийн хэрэглэгчийн хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, нууцлал, аюулгүй байдлыг хуульд заасны дагуу хангах;

8.1.10.зохицуулагч байгууллагаас шаардсан баримт бичиг, мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж, хүргүүлэх;

8.1.11.санхүүгийн хэрэглэгчид санхүүгийн үйлчилгээ, зээлийн бодит өртгийг танилцуулах;

8.1.12.санхүүгийн үйлчилгээний гэрээтэй уншиж танилцах нөхцөл, боломжоор санхүүгийн хэрэглэгчийг хангах;

8.1.13.эрх бүхий албан тушаалтан, ажилтныг энэ хуулийн 23.1-т заасан хөтөлбөрийн дагуу сургалтад хамруулах;

8.1.14.энэ хуулийн 6.1.6-д заасан нөхцөл бий болоход тухайн үйлчилгээг авснаас хойших ашигласан хугацаанд ногдох санхүүгийн үйлчилгээний үнэ, төлбөрөөс бусад шимтгэл, хураамж, нэмэлт төлбөр, торгуулийг санхүүгийн хэрэглэгчээс авахгүй байх;

8.1.15.санхүүгийн хэрэглэгч санхүүгийн үйлчилгээтэй холбогдуулах санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллагад гомдол гаргасан бол санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч өөрийн буруугүй болохыг нотлох;

8.1.16.олон нийтийн санхүүгийн боловсролыг дэмжих;

8.1.17.ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан санхүүгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон тусгайлсан бодлого, журамтай байх.

8.2.Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомжийн дагуу санхүүгийн хэрэглэгчид дараах тайлбар, мэдээллийг өгөх үүрэгтэй.

8.2.1.санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомжийн дагуу харилцагчаас мэдээлэл, баримт бичиг шаардах, харилцагчийг таньж мэдэх болон эрсдэлийн түвшнийг тодорхойлох арга хэмжээ авах болсон үндэслэлийг санхүүгийн хэрэглэгчид тайлбарлах бөгөөд уг тайлбарт “мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу” гэсэн ерөнхий үндэслэлийг дурдана.

8.2.2.энэ зүйлийн 8.2.1-д заасан тайлбарыг өгөхдөө тухайн харилцагчийг сэжигтэйд тооцсон эсэх, сэжигтэй гүйлгээний тайлан илгээсэн эсэх, дотоод эрсдэлийн үнэлгээ, шалгалтын нарийвчилсан мэдээллийг ил болгохыг хориглоно.

## **9 дүгээр зүйл. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид хориглох зүйл**

9.1. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид бусад хууль тогтоомжид зааснаас гадна дараах зүйлийг хориглоно:

9.1.1. санхүүгийн хэрэглэгчид төөрөгдүүлэхүйц, бодит бус мэдээлэл өгөх, түгээх;

9.1.2. санхүүгийн хэрэглэгчид санхүүгийн үйлчилгээ авах, бусад санхүүгийн үйлчилгээг давхар авах, гэрээ байгуулахыг тулган шаардах;

9.1.3. санхүүгийн хэрэглэгчийн санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийг чөлөөтэй сонгох эрхийг хязгаарлах;

9.1.4. хууль тогтоомжоор тусгайлан зөвшөөрснөөс бусад тохиолдолд энэ хууль болон бусад хуулиар тогтоосон хариуцлагаас өөрийгөө чөлөөлөх, эсхүл хариуцлагыг хязгаарласан нөхцөлтэй гэрээг санхүүгийн хэрэглэгчтэй байгуулах;

9.1.5. гэрээнд зааснаас бусад аливаа хүү, анз, хураамж, шимтгэл, нэмэлт төлбөр шаардах;

9.1.6. санхүүгийн хэрэглэгчид сэтгэл санааны болон бусад хэлбэрийн дарамт үзүүлэх, санхүүгийн хэрэглэгчийн мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд дамжуулах, түгээх;

9.1.7. энэ хуулийн 6.1.6-д заасан нөхцөл бий болоход санхүүгийн хэрэглэгчээс торгууль, хураамж, шимтгэл, тэдгээртэй адилтган тооцох аливаа төлбөр авахыг хориглоно.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГА БА МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ**

### **10 дугаар зүйл. Санхүүгийн үйлчилгээнд тавигдах шаардлага**

10.1. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь санхүүгийн үйлчилгээг сурталчлах, санхүүгийн хэрэглэгчийн оновчтой шийдвэр гаргалтыг дэмжих зорилгоор санхүүгийн үйлчилгээний танилцуулгыг олон нийтэд мэдээлнэ.

10.2. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь санхүүгийн үйлчилгээний нөхцөл, бодит өртөг, түүний задаргаа, төлбөрийн хуваарь, онцлог, эрсдэл болон үр дагаврын талаарх бүрэн гүйцэд, үнэн зөв, ойлгомжтой, харьцуулж болохуйц мэдээллээр санхүүгийн хэрэглэгчийг хангана.

10.3. Санхүүгийн үйлчилгээний танилцуулгад энэ хуулийн 10.2-т заасан мэдээллээс гадна санхүүгийн хэрэглэгчийн гомдол барагдуулах журам, бүтцийн талаарх мэдээллийг тусгана.

10.4. Энэ хуулийн 10.2-т заасан мэдээлэл болон хэрэглэгчтэй байгуулах гэрээ нь танилцахад тод, гаргацтай, уншигдахуйц тодорхой байна.

10.5. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч санхүүгийн хэрэглэгчтэй гэрээ байгуулахдаа энэ хуулийн 10.2-т заасан мэдээллээр хангаснаа нотолж, хяналтын хуудсаар баталгаажуулна.

10.6. Санхүүгийн үйлчилгээний танилцуулгад орсон өөрчлөлтийг тухай бүр олон нийтэд мэдээлнэ.

10.7. Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 10.6-д заасан өөрчлөлт нь санхүүгийн хэрэглэгчтэй байгуулсан гэрээний нөхцөлийг өөрчлөхөөр бол санхүүгийн хэрэглэгч уг нөхцөлийг бичгээр зөвшөөрсөн тохиолдолд хүчин төгөлдөр болно.

10.8. Санхүүгийн үйлчилгээний танилцуулгад тавигдах нийтлэг шаардлага, агуулгыг Зохицуулагч байгууллага тогтооно.

#### **11 дүгээр зүйл. Мэдээллийн ил тод байдал**

11.1. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь хуульд заасан болон Зохицуулагч байгууллагаас тогтоосон бусад мэдээллийг нийтлэх, өөрийн цахим хуудсанд байршуулах зэргээр олон нийтэд нээлттэй байлгана.

11.2. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэдээллийн илт тод байдлын журмыг Зохицуулагч байгууллага батална.

### **ТАВДУГААР БҮЛЭГ ГОМДОЛ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

#### **12 дугаар зүйл. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид гомдол гаргах**

12.1. Санхүүгийн хэрэглэгч санхүүгийн үйлчилгээтэй холбоотой хууль болон гэрээгээр олгогдсон өөрийн эрх зөрчигдсэн гэж үзвэл санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид гомдол гаргана.

12.2. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч энэ хуулийн 8.1.5-д заасан журмыг үйлчилгээний нэгж болон өөрийн цахим хуудсанд байршуулна.

12.3. Энэ хуулийн 8.1.5-д заасан журамд санхүүгийн хэрэглэгчийн гомдлыг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа, түүний дараалал, гомдлыг шийдвэрлэсэн хариуг хүргэх арга, хэлбэрийг тодорхой тусгана.

12.4.Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч гомдлыг амаар, утсаар, бичгээр, цахим шуудан болон цахим хуудас зэргээр үнэ төлбөргүй хүлээн авна.

12.5.Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч санхүүгийн хэрэглэгчийн гомдлыг хүлээн авснаас хойш шууд шийдвэрлэх боломжтой бол ажлын гурав хүртэл өдөр, бусад гомдлыг 30 хоногт багтаан шийдвэрлэнэ.

12.6.Гомдол шийдвэрлэсэн шийдвэрийг санхүүгийн хэрэглэгч эс зөвшөөрсөн, эсхүл энэ хуульд заасан хугацаанд шийдвэрлээгүй тохиолдолд Санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллагад гомдол гаргах эрхтэй талаар санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч санхүүгийн хэрэглэгчид мэдэгдэнэ.

12.7.Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь Санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллагатай харилцах эрх бүхий ажилтныг томилж ажиллуулна.

12.8.Санхүүгийн хэрэглэгч нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн шийдвэрийг эс зөвшөөрсөн, эсхүл энэ хуулийн 12 дугаар зүйлийн 12.5-д заасан хугацаанд гомдлыг шийдвэрлээгүй тохиолдолд гомдол шийдвэрлэх хугацаа дууссанаас хойш Санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллагад Иргэний хуульд заасан хөөн хэлэлцэх хугацааг баримтлан гомдол гаргаж болно.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ САНХҮҮГИЙН МАРГААН ШИЙДВЭРЛЭХ БАЙГУУЛЛАГА**

**13 дугаар зүйл.Санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллагын эрх зүйн байдал**

13.1.Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч болон санхүүгийн хэрэглэгчийн хооронд гарсан санхүүгийн үйлчилгээнд холбогдох маргааныг үнэ төлбөргүйгээр түргэн шуурхай, хараат бусаар шийдвэрлэх чиг үүргийг бие даасан, мэргэшсэн Санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллага хэрэгжүүлнэ.

13.2.Санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллага нь төрөөс үүсгэн байгуулсан, төр, хувийн хэвшил зэрэг аливаа этгээдээс хараат бус, бие даасан энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хуулийн этгээд бөгөөд тогтоосон загвараар хийсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ. Санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллага өөрийн бэлгэдэл тэмдэгтэй байж болно.

13.3.Санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллага нь Удирдах зөвлөл, маргааныг хянан шийдвэрлэх омбудсман (цаашид “омбудсман” гэх) болон ажлын албанаас бүрдэнэ.

13.4.Санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллага албан татвар, хураамж шимтгэлээс чөлөөлөгдөнө.

**14 дүгээр зүйл.Санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллагын санхүүжилт**

14.1.Санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллагын эхлэлтийн санхүүжилтийг Монголбанкнаас бүрдүүлнэ.

14.2.Санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллагын санхүүжилт нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч бүх салбарын оролцогчдын жилийн хураамж, үйлчилгээний шимтгэл, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

14.3.Жилийн хураамж, үйлчилгээний шимтгэлийг санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн актив хөрөнгө, шийдвэрлэсэн маргааны тоонд үндэслэн санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллагын Удирдах зөвлөл тогтооно.

14.4.Удирдах зөвлөлийн дарга, гишүүний цалин хөлсний хэмжээг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо тогтооно.

14.5.Шаардлагатай тохиолдолд Санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор Монголбанк болон улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.

#### **15 дугаар зүйл.Удирдах зөвлөл**

15.1.Удирдах зөвлөл нь долоон гишүүнтэй байх бөгөөд Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос томилж, чөлөөлнө.

15.2.Удирдах зөвлөлийн дарга нь орон тооны, бусад гишүүд (цаашид хамтад нь “гишүүн” гэх) орон тооны бус байна.

15.3.Гишүүнийг зургаан жилийн хугацаагаар томилох бөгөөд нэг удаа улируулан томилж болно.

15.4.Гишүүний бүрэн эрх Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос томилсноор эхэлж, дараагийн гишүүнийг томилсноор дуусгавар болно.

15.6.Гишүүн нь банк, санхүү, эдийн засаг, хууль зүйн чиглэлээр мэргэшсэн, эдгээр салбарын хяналт зохицуулалт, ажлын дадлага туршлагатай дараах шаардлагыг хангасан иргэн байна:

15.6.1.Монгол Улсын 30 нас хүрсэн иргэн, ял шийтгэлгүй;

15.6.2.банк, санхүү, эдийн засаг, хууль зүйн мэргэжлээр магистрын болон түүнээс дээш зэрэг, цолтой.

15.6.3.Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн, төрийн улс төрийн бусад албан тушаалтан, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, төрийн захиргааны албан тушаалтан бус байх;

15.6.4.сүүлийн таван жилийн хугацаанд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байгаагүй байх.

15.7.Гишүүнийг сонгон шалгаруулах журмыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо батална.

15.8.Гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас 60-аас доошгүй хоногийн өмнө Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах тухай олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

15.9.Энэ хуулийн 15.7-т заасан шаардлагыг хангасан иргэн сонгон шалгаруулалтыг нийтэд мэдээлснээс хойш 30 хоногийн дотор нэр дэвших тухай хүсэлтээ Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ.

15.10.Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо ажлын хэсэг байгуулж, 60 хоногийн дотор сонгон шалгаруулалт явуулна. Ажлын хэсэг сонгон шалгаруулалтад хамгийн өндөр оноо авсан иргэдээс сул орон тоо гарсан гишүүний тоогоор нэр дэвшүүлж, Эдийн засгийн байнгын хороо нэр дэвшигчийн сонгол зохион байгуулна.

15.11.Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо долоо хоногийн дотор хэлэлцэж, томилох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

15.12.Гишүүнд нэр дэвшигчийг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн олонх дэмжээгүй бол 14 хоногийн дотор энэ хуульд заасан журмын дагуу дахин сонгон шалгаруулалт зохион байгуулж, хамгийн өндөр оноо авсан иргэдээс дарааллын зарчмаар өөр иргэний нэрийг дэвшүүлнэ.

15.13.Гишүүнд нэр дэвшигчийг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн олонх дэмжээгүй бол тухайн иргэнийг дахин нэр дэвшүүлэхгүй.

15.14.Гишүүнийг томилохдоо жендерийн тэгш байдлыг харгалзан үзэх бөгөөд энэ хуулийн 15.1-д заасан гишүүний 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байна.

15.15.Гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болохоос өмнө хуульд заасан үндэслэлээр албан тушаалаасаа чөлөөлөгдсөн, огцорсон, нас барсан тохиолдолд Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо 60 хоногийн дотор энэ хуульд заасны дагуу нөхөн томилно.

15.16.Удирдах зөвлөлийн даргын түр эзгүйд гишүүдээс хамгийн удаан жил ажилласан гишүүн, энэхүү шаардлагыг хэд хэдэн гишүүн хангаж байвал тэдгээрийн хамгийн ахмад настай гишүүн даргын үүргийг түр орлон гүйцэтгэнэ.

15.17.Удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг дор дурдсанаас бусад тохиолдолд үүрэгт ажлаас чөлөөлөхийг хориглоно:

15.17.1.ёс зүйн ноцтой зөрчил гаргасан;

15.17.2.эрүүл мэндийн хувьд ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон;

15.17.3.өөрөө хүсэлт гаргасан;

15.17.4.гэмт хэрэг үйлдсэн болохыг эрх бүхий байгууллагаас тогтоосон.

15.18.Удирдах зөвлөлийн дарга, гишүүн нь омбудсманы маргаан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, шийдвэр гаргахад нөлөөлөхийг хориглоно.

15.19.Удирдах зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

15.19.1.омбудсманы хараат бус, бие даасан байдлыг хангах;

15.19.2.омбудсманы үйл ажиллагааны үр дүн болон үр ашигт байдалд хяналт тавих;

15.19.3.омбудсман болон ажлын албаны орон тоо, цалин хөлсний хэмжээг үндэслэлтэй тогтоох;

15.19.4.омбудсманы сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, омбудсманыг томилох, чөлөөлөх;

15.19.5.омбудсманы ёс зүйн дүрэм, маргаан шийдвэрлэх журмыг батлах;

15.19.6.санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллагын гүйцэтгэлийн жилийн төлөвлөгөөг батлах;

15.19.7.санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэх;

15.19.8.Зохицуулагч байгууллагатай зөвшилцөн Санхүүгийн омбудсманы үйл ажиллагааны журмыг батлах.

15.20.Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь хуралдаан байх бөгөөд дэгээ өөрөө тогтооно.

15.21.Удирдах зөвлөлийн шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна.

15.22.Санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллага гомдол, маргаан шийдвэрлэсэн талаарх статистик мэдээллийг улирал тутам гаргаж дараа

улирлын эхний 10 хоногийн дотор Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, Зохицуулагч байгууллагад хүргүүлнэ.

15.23.Санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллага энэ хуулийн 15.22-т заасан статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийж санал, дүгнэлтийг Зохицуулагч байгууллагад хүргүүлнэ.

### **16 дугаар зүйл.Омбудсман**

16.1.Омбудсман нь энэ хуулийн хүрээнд санхүүгийн хэрэглэгчээс гаргасан санхүүгийн үйлчилгээтэй холбоотой гомдол, маргааныг хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

16.2.Омбудсман нь энэ хуулийн 15.3-т заасан шаардлагыг хангасан иргэн байна.

16.3.Омбудсманыг дор дурдсанаас бусад тохиолдолд үүрэгт ажлаас чөлөөлөхийг хориглоно:

15.3.1.ёс зүйн ноцтой зөрчил гаргасан;

15.3.2.эрүүл мэндийн хувьд ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон;

15.3.3.өөрөө хүсэлт гаргасан;

15.3.4.гэмт хэрэг үйлдсэн болохыг эрх бүхий байгууллагаас тогтоосон.

16.4.Омбудсман нь хараат бус, бие даасан байдлаар ажиллаж, гомдол, маргааныг түргэн шуурхай, шударгаар шийдвэрлэх үүрэгтэй.

16.5.Удирдах зөвлөл энэ хуулийн 16.4-т заасан үүргээ биелүүлээгүй омбудсманыг нэн даруй чөлөөлнө.

### **17 дугаар зүйл.Омбудсманы эрх зүйн хамгаалалт, баталгаа**

17.1.Омбудсман нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дараах баталгаагаар хангагдана:

17.1.1.эрх хэмжээнийхээ хүрээнд хууль ёсны дагуу гаргасан шийдвэрийг биелүүлээгүй, эсхүл түүнийг биелүүлснээс санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч, хэрэглэгч, гуравдагч этгээдэд учирсан хохирлыг хариуцахгүй;

17.1.2.хуулиар хүлээлгэсэн албан үүрэгтэй нь холбоотойгоор заналхийлэх, сүрдүүлэх, амь бие, эрүүл мэндэд нь халдах аливаа хууль бус үйлдлээс омбудсман, түүний гэр бүлийн гишүүдийг төр хамгаалах;

17.1.3.үүргээ гүйцэтгэх үедээ эрүүл мэнд нь хохирсон буюу амь насаа алдсан тохиолдолд түүнд болон түүний гэр бүлд Удирдах зөвлөлөөс тогтоосон журмын дагуу тэтгэвэр, тэтгэмж, зардлыг олгох.

17.2.Энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр омбудсманы бүрэн эрхийг хязгаарлах, түдгэлзүүлэх, дуусгавар болгохыг хориглоно.

17.3.Омбудсманы хараат бус байдалд халдсан, омбудсманы үйл ажиллагаанд саад учруулсан хэн боловч хуулийн хариуцлага хүлээнэ.

17.4.Хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж гаргасан шийдвэртэй нь холбоотой аливаа маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль зүйн туслалцаа авах, холбогдох бусад зардлыг Санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллага хариуцна.

## **18 дугаар зүйл.Ажлын алба**

18.1.Ажлын алба нь эдийн засаг, санхүү, банк, хууль эрх зүй, мэдээллийн технологи, хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр мэргэшсэн ажилтнуудаас бүрдэх бөгөөд санхүүгийн боловсрол олгох, омбудсманы маргаан хянан шийдвэрлэх үйл ажиллагааг явуулахад туслах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

18.2.Ажлын албаны дарга, ажилтнуудыг Удирдах зөвлөл нээлттэй сонгон шалгаруулж, томилно.

## **19 дүгээр зүйл.Омбудсманы гомдол, маргаан хянан шийдвэрлэх журам**

19.1.Санхүүгийн хэрэглэгчээс Санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллагад хандан гомдол гаргах, гомдол, маргааныг судлах, хянан шийдвэрлэх үйл ажиллагааны журмыг Зохицуулагч байгууллагатай зөвшилцөж, олон нийтийн саналыг авсны үндсэн дээр Удирдах зөвлөл батална.

19.2.Санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллага дараах тохиолдолд хүлээн авсан гомдлоор маргаан үүсгэхээс татгалзана:

19.2.1.энэ хуульд заасан шаардлагыг хангаагүй;

19.2.2.тухайн гомдлыг санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч шийдвэрлэж, гомдлыг бүрэн барагдуулсан;

19.2.3.тухайн гомдлыг омбудсман, шүүх болон бусад хууль хяналтын байгууллага хянаж байгаа, эсхүл өмнө нь шийдвэрлэсэн;

19.2.4.гомдлын шинж чанар нь шүүхээр шийдвэрлэхэд илүү зохимжтой гэж омбудсман үзсэн.

19.3.Омбудсман маргаан үүсгэхээс татгалзсан бол санхүүгийн хэрэглэгчид үндэслэл бүхий шийдвэрээ ажлын 3 өдрийн дотор бичгээр мэдэгдэнэ.

## **20 дугаар зүйл.Баримт, мэдээлэл гаргуулах**

20.1.Омбудсман маргаан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт, мэдээллийг маргалдагч талуудаас шаардах эрхтэй.

20.2.Маргалдагч талууд энэ хуулийн 20.1-д заасан шаардлагын дагуу омбудсманы тогтоосон хугацаанд баримт мэдээллийг хүргүүлэх үүрэгтэй.

20.3.Энэ зүйлд заасан шаардлагыг маргалдагч талууд тогтоосон хугацаанд зохих ёсоор биелүүлээгүй бол омбудсман гомдлыг буцаах, эсхүл маргааныг аль нэг талд ашигтайгаар шийдвэрлэх эрхтэй.

20.4.Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч энэ хуулийн 8.1.15-т заасны дагуу өөрийн буруугүй болохыг нотлох үүрэгтэй.

## **21 дугаар зүйл.Омбудсманы шийдвэр**

21.1.Омбудсман нь энэ хуулийн 4.1.3-т заасан санхүүгийн үйлчилгээ болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100 дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүн бүхий гомдол, маргааныг хянан шийдвэрлэнэ.

21.2.Омбудсманы хүлээн авсан гомдол, маргааныг талуудын харилцан зөвшилцөлд хүргэх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

21.3.Омбудсман маргаан шийдвэрлэхдээ холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, санхүүгийн салбарын тогтсон жишгийг баримтлан, санхүүгийн хэрэглэгчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаална.

21.4.Талууд маргааныг зөвшилцлөөр шийдвэрлэж эвлэрсэн бол омбудсман эвлэрлийн гэрээний үндсэн нөхцөлүүдийг бүртгэн авна. Зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд шударга ёс, эрх зүйн үндсэн зарчмуудыг баримтлан маргааныг хянан шийдвэрлэж, талуудад шийдвэрээ бичгээр хүргүүлнэ.

21.5.Омбудсманы шийдвэрийг зөвхөн санхүүгийн хэрэглэгч хүлээн зөвшөөрөөгүй бол шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Иргэний хэргийн шүүхэд гомдол гаргаж болно.

21.6.Энэ хуулийн 21.5-т заасан омбудсманы шийдвэрт холбогдох маргааныг Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар, Улсын дээд шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.

21.7.Санхүүгийн хэрэглэгч энэ хуулийн 21.5-д заасан хугацаанд шүүхэд нэхэмжлэл гаргаагүй бол омбудсманы шийдвэр эцсийнх болно.

21.8.Омбудсманы шийдвэр энэ хуулийн 21.7-д заасны дагуу эцсийнх болсон тохиолдолд талууд шүүхэд энэ талаар гомдол гаргах эрхгүй.

21.9.Омбудсманы шийдвэр гомдол, маргааныг гомдол гаргагчийн талд шийдвэрлэсэн бол санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид гомдол гаргагчийн хохирлыг барагдуулах, бусад замаар зөрчлөө арилгахыг даалгасан хэлбэртэй байж болно.

21.10.Энэ хуулийн 21.7-д заасан шийдвэрийг санхүүгийн хэрэглэгч нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу шүүхээр баталгаажуулж, шийдвэрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу гүйцэтгүүлнэ.

## **22 дугаар зүйл. Санхүүгийн маргаан шийдвэрлэх үйл ажиллагааг олон нийтэд тайлагнах**

22.1. Санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллага улирал бүр өөрийн үйл ажиллагаа, гомдол, маргаан хянан шийдвэрлэсэн шийдвэрийн тоо, төрөл болон чиг хандлагын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэнэ.

22.2. Санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллага маргаан хянан шийдвэрлэсэн шийдвэрийг хувь хүний нууцлалыг хамгаалж, санхүүгийн омбудсманы цахим хуудсанд нийтэлнэ.

22.3. Санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллага иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд өөрийн үйл ажиллагааг олон нийтэд таниулан сурталчилна.

22.4. Санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллага энэ хуулийн 21.1-т зааснаас бусад төрлийн санхүүгийн үйлчилгээтэй төсөөтэй гомдолд дүн шинжилгээ хийж, санал дүгнэлтийг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж болно.

## **ДОЛООДУГААР БҮЛЭГ САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ**

### **23 дугаар зүйл. Санхүүгийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагаа**

23.1. Иргэдийн санхүү, эдийн засгийн боловсролыг дээшлүүлэх стратегийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

23.2. Энэ хуулийн 23.1-д заасан хөтөлбөр дараах шаардлагыг хангасан байна:

23.2.1. үндэсний хөгжлийн бодлогод тулгуурлах;

23.2.2. төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл зэрэг эдийн засаг, санхүүгийн салбарын хөгжилтэй холбоотой гарсан бодлогын баримт бичигтэй уялдах;

23.2.3. олон улсын жишиг, шилдэг туршлагад нийцсэн байх.

23.3.Санхүүгийн боловсрол дээшлүүлэх үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

- 23.3.1.хүртээмжтэй байх;
- 23.3.2.цогц мэдээ, мэдээллийг агуулсан байх;
- 23.3.3.тасралтгүй байх;
- 23.3.4.хяналт, үнэлгээг тогтмол хийдэг байх;
- 23.3.5.олон нийт, хүний нөөцийг чадавхжуулах зорилготой байх;

23.4.Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх бүхий албан тушаалтан, ажилтныг мэргэшүүлэх, ёс зүйн болон санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлийн сургалтын агуулга, төлөвлөгөөг зохицуулагч байгууллага болон салбар бүрийн мэргэжлийн холбоо энэ хуулийн 23.1-т заасан хөтөлбөрт нийцүүлэн хамтран батална.

23.5.Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь санхүүгийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг энэ хуулийн 23.4-т заасан төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.

23.6.Мэргэжлийн холбоо нь энэ хуулийн 23.1-д заасан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санхүүгийн маргаан таслах байгууллага, зохицуулагч байгууллагатай хамтран ажиллана.

23.7.Мэргэжлийн холбоо санхүүгийн боловсролыг дээшлүүлэх асуудал хариуцсан салбар зөвлөлтэй байх бөгөөд энэ хуулийн 23.4-т заасан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, үнэлэх, санал боловсруулах, бусад зохион байгуулалтын арга хэмжээ авах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

23.8.Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь жил бүр үйл ажиллагааны цэвэр ашгийн нэг хувиас доошгүй хувийг олон нийтэд санхүүгийн боловсрол олгох ажилд зарцуулна.

## **НАЙМДУГААР БҮЛЭГ ЗОХИЦУУЛАГЧ БАЙГУУЛЛАГА**

### **24 дүгээр зүйл.Зохицуулагч байгууллагын бүрэн эрх**

24.1.Зохицуулагч байгууллага нь хуульд заасан чиг үүргээс гадна санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хүрээнд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

24.2.Зохицуулагч байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

24.2.1.санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах;

24.2.2.санхүүгийн боловсрол дээшлүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

24.2.3.санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтыг хэрэгжүүлэх;

24.2.4.санхүүгийн үйлчилгээнд хамрагдах хэлбэрээр санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн зан төлөвийг үнэлж, үйл ажиллагаанд хяналт тавих;

24.2.5.санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр бусад эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах;

24.2.6.санхүүгийн хэрэглэгч, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаа хууль тогтоомж зөрчсөн нь гэмт хэргийн шинжтэй байвал эрх бүхий байгууллагад шилжүүлэх;

24.2.7.хуульд заасан бусад.

24.3.Зохицуулагч байгууллага энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд дараах дүрэм, журам, заавар, аргачлалыг батална:

24.3.1.санхүүгийн үйлчилгээнд тавигдах нөхцөл, шаардлага, хязгаарлалт;

24.3.2.санхүүгийн хэрэглэгчийг мэдээллээр хангасныг нотлох хяналтын хуудасны жишиг загвар;

24.3.3.санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг үнэлэх аргачлал;

24.3.4.санхүүгийн хэрэглэгчийн гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн тайлан, мэдээний загвар;

24.3.5.хуульд заасан бусад.

24.4.Зохицуулагч байгууллага энэ хуулийн 24.3-т заасан дүрэм, журам, заавар, аргачлалыг батлахдаа санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс гарах холбогдох зардал, санхүүгийн хэрэглэгчид хүрэх үр ашиг, санхүүгийн хүртээмжид үзүүлэх нөлөөлөл зэргийг харгалзан үзнэ.

24.5.Зохицуулагч байгууллагууд зээлийн бодит өртгийг тооцох аргачлалыг хамтран батална.

24.6.Зохицуулагч байгууллага санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах зорилгоор санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид дараах арга хэмжээг авах эрхтэй:

24.6.1.энэ хуульд заасан үүргээ зөрчсөн санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс гаргасан алдаа дутагдлыг арилгахыг шаардах;

24.6.2.санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч санхүүгийн хэрэглэгчид хохирол учруулсан бол хохирлыг арилгах, санхүүгийн хэрэглэгчийн үндэслэлгүйгээр болон илүү төлсөн төлбөрийг буцаан олгохыг даалгах;

24.6.3.санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн буруу ташаа мэдээлэл, мэдэгдэл, зар сурталчилгааг залруулахыг шаардах;

24.6.4.санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийг тодорхой санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийг хэсэгчлэн болон бүхэлд нь хязгаарлах, түдгэлзүүлэх, зогсоох;

24.6.5.санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны зөвшөөрлийг хуульд заасны дагуу түдгэлзүүлэх, хүчингүй болгох, хасах;

24.6.6.шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээ.

24.7.Зохицуулагч байгууллага энэ хуулийн 24.6-д заасныг хэрэгжүүлэхдээ тус тусын хуульд заасан албадлагын арга хэмжээг авна.

24.8.Зохицуулагч байгууллага санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, олон нийтэд санхүүгийн боловсрол олгох, дээшлүүлэх чиг үүрэг бүхий бие даасан нэгж, орон тоотой байна.

24.9.Зохицуулагч байгууллага санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах зорилгоор төрийн бусад эрх бүхий байгууллагатай хамтарсан хяналт шалгалт хийж болно.

24.10.Зохицуулагч байгууллага энэ хуулийн 24.2.4-т заасныг хэрэгжүүлэхдээ шаардлагатай тохиолдолд гэрээний үндсэн дээр бусад этгээдээр гүйцэтгүүлж болно.

## **ЕСДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД**

### **25 дугаар зүйл.Шударга бус зээлийн эсрэг арга хэмжээ**

25.1.Банк, эрх бүхий хуулийн этгээд болон бусад зээлдүүлэгч этгээд нь зээлдэгчийн орлого, бусад төлбөрийн үүргийг харгалзан зээлдэгчийн төлбөрийн чадварт нийцүүлэн зээл олгоно.

25.2.Энэ хуулийн 25.1-д заасан зээлдүүлэгчээс зээл олгоход дараах зүйлийг хориглоно:

25.2.1.зээлийн хүүг урьдчилан авах;

25.2.2.зээлийн бодит өртгөөс бусад аливаа хураамж, шимтгэл, нэмэлт төлбөр авах;

25.2.3.зээл авахыг тулган шаардах;

25.2.4.зээлийн нөхцөлийн талаарх мэдээллийг нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, зээлдэгчийг төөрөгдөлд оруулах.

25.3.Банк, зээлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхэлж байгаа эрх бүхий хуулийн этгээдээс бусад хувь хүн, хуулийн этгээд аливаа зар сурталчилгаа, бусад мэдээллийн хэрэгслийг ашиглаж, олон нийтэд санал болгон, зээл олгохыг хориглоно.

25.4.Зээлдүүлэгч зээлийн төлбөр барагдуулахдаа хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх зан суртахууны хэм хэмжээг баримтлан, зээлдэгчийн хууль ёсны эрх, нэр хүндийг хүндэтгэн, хувийн нууцыг хадгалж, хамгаална.

25.5.Зээлийн гэрээг бичгээр эсхүл цахим хэлбэрээр хийх бөгөөд энэ шаардлагыг хангаагүй бол зээлдүүлэгч хүү авах эрхээ алдана.

## **26 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

26.1.Энэ хуулийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль эсхүл Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## **27 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

27.1.Энэ хуулийг 2027 оны ... сарын ... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

## ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт доор дурдсан агуулгатай 11.36 дүгээр зүйл нэмсүгэй:

**“11.36 дугаар зүйл.Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль зөрчих**

1.Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч:

1.1.санхүүгийн хэрэглэгчийн бодит санхүүгийн чадамж, хэрэгцээнд үндэслэн санхүүгийн үйлчилгээ үзүүлэх үүргээ биелүүлээгүй;

1.2.гэрээнд өөрчлөлт оруулах санал гаргах, татгалзах эрхтэй болохыг гэрээ байгуулахаас өмнө санхүүгийн хэрэглэгчид мэдэгдэх үүргээ биелүүлээгүй;

1.3.санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхээс бусад тохиолдолд үндэслэл бүхий тайлбарыг санхүүгийн хэрэглэгчид мэдэгдэх үүргээ биелүүлээгүй;

1.4.санхүүгийн хэрэглэгчтэй гэрээ байгуулахдаа тухайн гэрээний агуулга, нөхцөл, хүү, хураамж, шимтгэл, нэмэлт төлбөр, тэдгээрийг тооцож байгаа аргачлалыг танилцуулж, тайлбарлах үүргээ биелүүлээгүй;

1.5.санхүүгийн хэрэглэгчтэй харилцах, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх дотоод журам, бүтэцтэй байх үүргээ гүйцэтгээгүй;

1.6.санхүүгийн үйлчилгээний гэрээг уншиж танилцах боломжоор хангах үүргээ биелүүлээгүй;

1.7.эрх бүхий албан тушаалтан, ажилтныг Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд заасан хөтөлбөрийн дагуу сургалтад хамруулах үүргээ биелүүлээгүй;

1.8.санхүүгийн үйлчилгээний танилцуулга, түүнд оруулсан өөрчлөлтийг олон нийтэд мэдээлэх үүргээ биелүүлээгүй;

1.9.санхүүгийн үйлчилгээний нөхцөл, нийт өртөг, түүний задаргаа, төлбөрийн хуваарь, онцлог, эрсдэл болон үр дагаврын талаарх бүрэн гүйцэд, үнэн зөв, ойлгомжтой, харьцуулж болохуйц мэдээллээр санхүүгийн хэрэглэгчийг хангах үүргээ биелүүлээгүй;

1.10.санхүүгийн хэрэглэгчтэй гэрээ байгуулахдаа Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд заасан мэдээллээр хангаснаа нотолж, хяналтын хуудсаар баталгаажуулах үүргээ биелүүлээгүйгээс санхүүгийн хэрэглэгчид хохирол учруулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

## 2.Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч:

2.1.санхүүгийн хэрэглэгчийн гаргасан гомдлыг Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд заасан хугацаанд үнэ төлбөргүйгээр шийдвэрлэж, уг шийдвэрийн талаар санхүүгийн хэрэглэгчид бичгээр эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэх үүргээ биелүүлээгүй;

2.2.санхүүгийн хэрэглэгчээс гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн тухай нэгдсэн тайлан, мэдээг тогтоосон хугацаанд зохицуулагч байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй;

2.3.санхүүгийн хэрэглэгчид хохирол учруулсан нь тогтоогдсон тохиолдолд барагдуулах үүргээ биелүүлээгүй;

2.4.санхүүгийн хэрэглэгчийн хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, нууцлал, аюулгүй байдлыг хуульд заасны дагуу хангах үүргээ биелүүлээгүй;

2.5.хүүгийн түвшинг зээлийн бодит өртгөөр илэрхийлж санхүүгийн хэрэглэгчид танилцуулах үүргээ биелүүлээгүй;

2.6.санхүүгийн хэрэглэгчид төөрөгдүүлэхүйц, бодит бус мэдээлэл өгсөн, түгээсэн;

2.7.санхүүгийн үйлчилгээг тулгах, бусад санхүүгийн үйлчилгээг давхар авахыг шаардахгүй байх үүргээ биелүүлээгүй;

2.8.хууль тогтоомжоор тусгайлан зөвшөөрснөөс бусад тохиолдолд Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль болон бусад хуулиар

тогтоосон хариуцлагаас өөрийгөө чөлөөлөх, эсхүл хариуцлагыг хязгаарласан нөхцөлтэй гэрээг санхүүгийн хэрэглэгчтэй байгуулахгүй байх үүргээ биелүүлээгүй;

2.9.Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд заасны дагуу санхүүгийн хэрэглэгч санхүүгийн үйлчилгээ авснаас хойш ажлын 3 хоногийн дотор торгууль, хураамж, шимтгэл, төлбөргүйгээр буцаах, гэрээг цуцлах нөхцөл бий болоход санхүүгийн хэрэглэгчийн авсан санхүүгийн үйлчилгээтэй холбогдуулан төлсөн аливаа торгууль, хураамж, шимтгэл, төлбөрийг санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч буцаан олгох үүргээ биелүүлээгүй;

2.10.банк, эрх бүхий хуулийн этгээд болон бусад зээлдүүлэгч этгээд нь зээлдэгчийн орлого, бусад төлбөрийн үүргийг харгалзан зээлдэгчийн төлбөрийн чадварт нийцүүлэн зээл олгож, зээлдүүлэгч зээлийн төлбөр барагдуулахдаа хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх ёс суртахууны хэм хэмжээг баримтлан, зээлдэгчийн хууль ёсны эрх, нэр хүндийг хүндэтгэн, хувийн нууцыг хадгалж, хамгаалах үүргээ биелүүлээгүй;

2.11.гэрээнд зааснаас бусад аливаа хүү, анз, хураамж, шимтгэл, нэмэлт төлбөр шаардсан болон Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд заасан бусад үүргээ биелүүлээгүй;

2.12.банк, эрх бүхий хуулийн этгээд болон бусад зээлдүүлэгч этгээд нь зээлдэгчийн орлого, бусад төлбөрийн үүргийг харгалзан зээлдэгчийн төлбөрийн чадварт нийцүүлэн зээл олгох үүргээ биелүүлээгүй;

2.13.Банк, эрх бүхий хуулийн этгээд болон бусад зээлдүүлэгч этгээд зээлийн төлбөр барагдуулахдаа хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх ёс суртахууны хэм хэмжээг баримтлан, зээлдэгчийн хууль ёсны эрх, нэр хүндийг хүндэтгэн, хувийн нууцыг хадгалж, хамгаалах үүргээ биелүүлээгүйгээс зээлдэгч, санхүүгийн хэрэглэгчид хохирол учруулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Омбудсманы гомдол, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад аливаа хэлбэрээр нөлөөлөх, доромжлох, халдах, эсэргүүцэхийг оролдсон, эсхүл санхүүгийн маргаан шийдвэрлэх байгууллага, омбудсманы аюулгүй байдлын журам зөрчсөн бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.18 дахь заалтын "11.35," гэсний дараа "11.36," гэж, мөн зүйлийн 6.19 дэх заалтын "11.35" гэсний дараа "11.36" гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 183 дугаар зүйлийн 183.1 дэх хэсгийн “акт,” гэсний дараа “Омбудсманы шийдвэр,” гэж, 184 дүгээр зүйлийн 184.1 дэх хэсгийн “акт” гэсний дараа “, Омбудсманы шийдвэр” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 184 дүгээр зүйлийн “актын” гэснийг “акт, Омбудсманы шийдвэрийн” гэж, 184 дүгээр зүйлийн 184.2 дахь хэсгийн “актын” гэснийг “акт, Омбудсманы шийдвэрийн” гэж, 184 дүгээр зүйлийн 184.3 дахь хэсгийн “актыг” гэснийг “акт, Омбудсманы шийдвэрийг” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ  
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.4 дэх заалтын “шийдвэр” гэсний дараа “, Омбудсманы шийдвэр” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар  
сарын ... өдөр

Улаанбаатар хот

## САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

**1 дүгээр зүйл.** Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, Хууль зүйн байнгын хороо, Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороо Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон бэлтгэл ажлыг 2027 оны 1 дүгээр сарын 04-ний өдрийн дотор зохион байгуулж хангасан байна.

**2 дугаар зүйл.** Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн Тав болон Зургадугаар бүлгийг 2027 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ